



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.3, 33 дугаар зүйлийн 33.6, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэхийг Стратеги удирдлагын газар /Б.Бундхорол/, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын газар /С.Оюунгэрэл/-т тус тус даалгасугай.

3. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /У.Хүрэлсүх/, Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/, холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэхэд бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулахыг Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч бөгөөд тэргүүлэх аудитор /О.Тэнгис/-т даалгасугай.

5. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /С.Оюунгэрэл/-т даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /Б.Батдэлгэр/-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ





АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	2
Хавсралтууд	2
Хүснэгтэн мэдээллийн жагсаалт	3
Графикийн жагсаалт.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦООГ ГАЖУУДУУЛСНААС САЛБАРЫН БОДЛОГО АЛДАГДАХ, ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ БАТЛАХ ЗӨРЧИЛ ХЭВЭЭР БАЙНА.....

10

Монгол Улсын хөгжлийн дунд болон богино хугацааны бодлого, батлагдсан төсөв хоорондын уялдаа бүрэн хангагдахгүй байгаа нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна

10

Засгийн газар Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн саналд тусгаагдаагүй 266 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд нэгтгэн Улсын Их Хуралд өргөн барьжээ.....

12

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд төсөвлөлтийн шаардлага хангаагүй 538 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ

13

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг салбарын бодлогын хүрээнд орон нутаг, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэх шаардлагатай байна

13

Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг баталснаас гүйцэтгэл удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болжээ.....

14

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд цахим системийг нэвтрүүлсэн байна

16

БҮЛЭГ 2. УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 77.5 ХУВЬТАЙ БАЙНА.....

17

Худалдан авах ажиллагааг оройтож зохион байгуулснаас төсөл, арга хэмжээний гүйцэтгэл тайлант онд бүрэн хэрэгжихгүй байх эрсдэл үүсжээ

17

Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан Төсвийн ерөнхийлөн захирагчдад Сангийн яамнаас өгсөн дундаж үнэлгээ 73.2 хувьтай байна

18

Магадлалаар баталгаажаагүй төсөвт өртгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас үр ашиггүй зардал гарах эрсдэлийг үүсгэсэн байна

18

Засгийн газрын 2018 оны “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 386 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангаагдаагүй байна

23

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хуульд батлуулснаас хөрөнгийн зохицуулалт хийх шаардлага үүссэн байна.....

23

Барилга угсралтын үе шатны ажилд зохиогчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт зөрчигдөж байна

24

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний 7.7 хувь буюу 98 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 14.4 хувь буюу 184 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дутуу байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна

25

Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлээр 127.0 тэрбум төгрөгийн 265 зөрчил илэрсэн нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна

25

Төрийн аудитын байгууллагаас өмнөх онд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна

31

ДҮГНЭЛТ:

33

ЗӨВЛӨМЖ:

34



Товчилсон үгийн тайлбар

АТГД	Авлигатай тэмцэх газрын дарга
БД	Барилгын дүрэм
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ГХС	Гадаад харилцааны сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЗГХЭГД	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУИХД	Монгол Улсын Их Хурлын дарга
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУШС	Монгол Улсын Шадар сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
СБД	Сүхбаатар дүүрэг
СЕХД	Сонгуулийн ерөнхий хорооны дарга
СС	Сангийн сайд
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨӨЗ	Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УБХЗ	Улаанбаатар хотын Захирагч
УДШЕШ	Улсын Дээд Шүүхийн ерөнхий шүүгч
УЕП	Улсын ерөнхий прокурор
УИХ	Улсын Их хурал
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УЦС	Усан цахилгаан станц
ҮАБЗД	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХЦД	Үндсэн хуулийн цэцийн дарга
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦАУЗБУК	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ШЕЗД	Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХС	Эрчим хүчний сайд

Хавсралтууд

Дугаар	Хавсралтын нэр	Хуудасны дугаар
1	Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуульд тусгаагүй үргэлжлэх төсөл, арга хэмжээний жагсаалт	38
2	Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулиар өртөг нэмэгдсэн үргэлжлэх төсөл, арга хэмжээний жагсаалт	40



3	Монгол Улсын 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ч хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт	43
4	Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын тусгагдсан ч хэрэгжилт дутуу төсөл, арга хэмжээний жагсаалт	47
5	Монгол Улсын сум, дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн /төрийн өмчийн/ барилгын хүчин чадлыг нормативт хэмжээтэй харьцуулсан байдал	55
6	Монгол Улсын сум, дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын /төрийн өмчийн/ барилгын хүчин чадлыг суралцаж буй хүүхдийн тоотой харьцуулсан байдал	56
7	Магадлалаар баталгаажсан төсвөөс гэрээний дүн давсан төсөл, арга хэмжээний жагсаалт	57

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт

Дугаар	Нэр	Хуудасны дугаар
1	Улсын төсвийн 2018, 2019 оны хөрөнгө оруулалт /тэрбум төгрөг/	7
2	Төсөл, арга хэмжээний санхүүжилт, ажлын гүйцэтгэл /тэрбум төгрөг/	7
3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж ашиглалтад орсон барилга, байгууламжийн судалгаа /хүчин чадал/	8
4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын салбараар ангилсан судалгаа /тэрбум төгрөг/	8
5	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт батлагдсан 2019 онд улсын төсвөөс санхүүжих төсөл, хөтөлбөрт оруулсан тодотгол /тэрбум төгрөг/	10
6	Төсвийн хязгаарт хөрөнгийн зардал тусгагдаагүй болон хязгаараас давсан ТЕЗ-дын мэдээлэл	11
7	Улсын төсвийн 2018, 2019 оны хөрөнгө оруулалтын харьцуулалт /тэрбум төгрөг/	11
8	Төсвийн хязгаар, ТЕЗ-дын төсвийн санал, Сангийн яамнаас төсвийн төслийг нэгтгэж боловсруулсан байдлыг харьцуулсан үзүүлэлт /тоо, сая төгрөг/	12
9	Шинээр эхлүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсөв баталгаажсан байдал /тоо, эзлэх хувь/	13
10	Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталсан төсөл, арга хэмжээ /сая төгрөг/	15
11	Хүснэгт 11. Хөрөнгө оруулалтын бус шинжтэй төсөл, арга хэмжээ /сая төгрөг/	15
12	ТЕЗ нарын худалдан авах ажиллагаанд өгсөн үнэлгээ /хувиар/	18
13	Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон барьцаа хөрөнгийн дансаар олгосон санхүүжилтийн дүн /сая төгрөг/	21
14	ТЕЗ-дын 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зохицуулалт хийсэн хөрөнгийн зардлын дүн /сая төгрөг/	23
15	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын илрүүлсэн зөрчлийн нэгтгэл /сая төгрөг/	26

Графикийн жагсаалт

Дугаар	Графикийн нэр	Хуудасны дугаар
1	Нэгдсэн төсөв болон улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн, нэгдсэн төсвийн хөрөнгийн зарлагад улсын төсвийн хөрөнгийн зарлагын эзлэх хувь /тэрбум төгрөг/	6
2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийн судалгаа /тэрбум төгрөг/	9
3	ТЕЗ-дын худалдан авах ажиллагаа зохион байгуулсан хугацаа /хувь, сараар/	17



Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2019 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” А/100 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Зорилтыг хангахын тулд дараах дэд асуудлын хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд санхүүжүүлэхээр баталсан 1281 төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний харьяа байгууллага болон төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт тавихтай холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Дараах хууль, эрх зүйн актыг аудитын гол шалгуур үзүүлэлтээр эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”;
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл;



- Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”;
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”;
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт;
- Барилгын норм ба дүрэм, бусад эрх зүйн актууд.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

УИХ-аас 2015 онд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг баталснаар Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчин бий болсон байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Дунд хугацааны буюу 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын дараах баримт бичиг байна”, 6.4.4-т “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гэж заасан бөгөөд улсын төсвийг хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх санхүүжилтийн нэг эх үүсвэр байхаар хуульчилсан байна.


Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 25 ТЕЗ-ийн төсвийн багцад 3,200.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1281 төсөл, арга хэмжээнд 1,553.4 тэрбум төгрөгийн санхүүжилт, гуравдугаар хавсралтаар Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн 518.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд 144.7 тэрбум төгрөгийг тус тус олгохоор баталжээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэлд хөрөнгийн зардлын хэмжээг 3,251.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ийн 9.2 хувьтай тэнцэхээр баталснаас гүйцэтгэлээр 3,016.7 тэрбум төгрөг буюу ДНБ-д эзлэх хэмжээ 8.2 хувь байгаа нь төсвийн хүрээний мэдэгдлээс 1.0 нэгж хувиар бага байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны гүйцэтгэлээр нийт хөрөнгийн зардлын 1,422.6 тэрбум төгрөг буюу 47.2 хувийг улсын төсөв, 137.4 тэрбум төгрөг буюу 4.6 хувийг концессын эргэн төлөлт, 96.6 тэрбум төгрөг буюу 3.2 хувийг стратегийн болон бусад хөрөнгийн санхүүжилт, 891.6 тэрбум төгрөг буюу 29.5 хувийг гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, 468.5 тэрбум төгрөг буюу 15.5 хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 13.4 хувь, улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 16.8 хувь, нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын 51.7 хувийг эзэлж байгаа нь сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.

График 1. Нэгдсэн төсөв болон улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн, нэгдсэн төсвийн хөрөнгийн зарлагад улсын төсвийн хөрөнгийн зарлагын эзлэх хувь /тэрбум төгрөг/



Эх сурвалж: ЯАГ, УСХ, Сангийн яам



Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтыг “Гаалийн шинэчлэл төслийг хэрэгжүүлэх”, “Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх”, “Өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх”, “Эрүүл мэндийн үйлчилгээг иргэдэд ойр байлгах, эмнэлгийн орчин нөхцөлийг сайжруулах” бодлогын зорилтуудыг хангахад голлон чиглүүлжээ.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар баталсан 1281 төсөл, арга хэмжээнээс 1,306.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 515.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 373 төсөл, арга хэмжээ буюу 29.1 хувь нь өмнөх оноос шилжсэн, 1,894.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,037.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 908 төсөл, арга хэмжээ буюу 70.9 хувийг тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулахад төсөл, арга хэмжээний тоо 71.5 хувиар, санхүүжих дүн 1.2 дахин буюу 931.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Хүснэгт 1. Улсын төсвийн 2018, 2019 оны хөрөнгө оруулалт /тэрбум төгрөг/

Санхүүжилтийн эх үүсвэр	2018 он				2019 он				Өмнөх жилээс өссөн, буурсан	
	TAX- ний тоо	Санхүү- жих дүн	Санхүүжилт Дүн	Хувь	TAX- ний тоо	Санхүү- жих дүн	Санхүүжилт Дүн	Хувь	Төлөв	Гүйц
Улсын төсөв	749	683.3	580.4	84.9	1281	1,553.4	1,422.6	91.6	870.1	842.2
Концессын эргэн төлөлт	5	82.9	79.0	95.3	12	144.7	137.4	95.0	61.8	58.4
Нийт дүн	754	766.2	659.4	86.1	1293	1,698.1	1,560.0	91.9	931.9	900.6

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 1,553.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоос 1,422.6 тэрбум төгрөг буюу 91.6 хувь, концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 12 төслийн эргэн төлөлтөд 144.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоос 137.4 тэрбум төгрөг буюу 94.9 хувийг тус тус олгож, нийт хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийг Сангийн яамнаас 1,560.0 тэрбум төгрөг буюу 91.9 хувь гэж тайлагнажээ.

Хүснэгт 2. Төсөл, арга хэмжээний санхүүжилт, ажлын гүйцэтгэл /тэрбум төгрөг/

Үүнээс:												
Д/д	ТЕЗ	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүү-жих дүн	Санхүүжилтийн гүйцэтгэл		Ажлын бодит гүйцэтгэлээр		Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон барьцаагаар		Зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ	
					Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	МУИХД	1	2.0	2.0	1.7	84.6	1.7	84.6			0.3	15.4
2	МУЕС	3	37.2	14.2	13.8	96.7	13.8	96.7			0.5	3.3
3	МУШС	9	24.0	6.4	6.3	98.4	6.3	98.4			0.1	1.6
4	ЗГХЭГД	67	62.5	38.7	35.0	90.5	30.8	79.6	4.2	10.8	3.7	9.5
5	БОАЖС	20	36.2	13.8	12.1	87.6	9.9	71.6	2.2	16.0	1.7	12.4
6	ГХС	2	2.9	2.9	2.9	99.7	2.9	99.7			0.0	0.3
7	СС	11	174.3	134.4	113.2	84.2	68.8	51.2	44.4	33.0	21.2	15.8
8	ХЗДХС	37	83.9	42.9	42.7	99.6	42.7	99.6			0.2	0.4
9	ХНХС	37	59.5	33.9	29.5	86.9	22.7	66.8	6.8	20.1	4.4	13.1
10	БХС	6	36.5	15.5	15.3	99.0	15.3	99.0			0.2	1.0
11	БХБС	160	347.4	141.4	138.5	98.0	131.8	93.2	6.7	4.7	2.9	2.0
12	БСШУСС	603	1,165.9	616.5	559.0	90.7	473.5	76.8	85.5	13.9	57.5	9.3
13	ЗТХС	141	675.2	241.8	226.1	93.5	194.9	80.6	31.2	12.9	15.7	6.5
14	УУХУС	1	2.0	2.0	-	0.0	-				2.0	100.0
15	ХХААХУС	38	40.7	29.5	28.3	95.8	22.6	76.5	5.7	19.3	1.3	4.2
16	ЭХС	28	200.7	97.2	86.2	88.8	81.3	83.7	4.9	5.0	10.9	11.2
17	ЭМС	107	233.1	104.2	96.2	92.3	68.3	65.5	27.9	26.8	8.0	7.7
18	АТГД	1	0.8	0.8	0.8	100.0	0.8	100.0			-	0.0
19	ҮАБЗНБД	1	0.2	0.2	0.2	99.8	0.2	99.8			0.0	0.2
20	ҮХЦД	1	0.5	0.5	0.5	96.0	0.5	96.0			0.0	4.0
21	УЕП	2	4.7	4.4	4.2	96.0	4.2	96.0			0.2	4.0
22	УДШЕШ	2	4.0	4.0	3.8	96.2	3.8	96.2			0.2	3.8
23	МУЕА	1	1.5	1.5	1.5	99.2	1.5	99.2			0.0	0.8
24	ШЕЗД	1	0.8	0.8	0.8	99.7	0.8	99.7			0.0	0.3
25	СЕХД	1	4.0	4.0	4.0	100.0	4.0	100.0			0.0	0.0
Улсын төсвийн дүн		1281	3,200.5	1,553.4	1,422.6	91.6	1,203.1	77.5	219.5	14.1	130.8	8.4
Концессын дүн		12	518.4	144.7	137.4	94.9	137.4	94.9	-	-	7.3	5.1
Нийт		1293	3,718.9	1,698.1	1,560.0	91.9	1,340.5	79.0	219.5	12.9	138.1	8.1

Эх сурвалж: УАГ, Сангийн яам



Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийг авч үзвэл, төлөвлөсөн санхүүжилтийн 79.0 хувь буюу 1,340.5 тэрбум төгрөгийг ажлын бодит гүйцэтгэлээр олгож, 12.9 хувь буюу 219.5 тэрбум төгрөгийг урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжүүлж, барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Харин ТЕЗ-дын тайлант онд зарцуулагдаагүй үлдэгдэл 130.8 тэрбум төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн бөгөөд үүний 63.8 тэрбум төгрөг буюу 48.8 хувь нь худалдан авах ажиллагааны хэмнэлт, 12.5 тэрбум төгрөг буюу 9.6 хувь нь ажлын гүйцэтгэл гараагүй, 54.5 тэрбум төгрөг буюу 41.6 хувь нь гэрээ байгуулаагүйгээс тус тус шалтгаалжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд 17110 суудалтай 46 сургууль, 10455 ортой 75 цэцэрлэг, 1580 ортой 14 дотуур байр, 348 ортой 30 эмнэлэг, 63.6 км автозам, 341.7 у/м гүүрийн байгууламж, 2000 км ЦДАШ, 4180 суудалтай 17 соёлын төв, дэд бүтцийн 39 барилга, байгууламж ашиглалтад орсон байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэн комисс хүлээн авч, байнгын ашиглалтад оруулсан төсөл, арга хэмжээний үр дүнг салбараар гаргаж өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад зам, тээврийн салбараас бусад салбарын барилга, байгууламжийн хүчин чадал өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж ашиглалтад орсон барилга, байгууламжийн судалгаа /хүчин чадал/

Барилга, байгууламжийн ангилал	Хэмжих нэгж	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	Өмнөх 5 жилийн дунджаас өссөн, буурсан
Хатуу хучилттай авто зам	км	435	1171.9	176.6	844.8	135.5	63.6	(489.2)
Төмөр бетон гүүр	у/м	1259	586.2	289.9	509.6	202.4	341.7	(227.7)
ЦДАШ	км	472	562.4	65.3	0	150	2000	1750.1
Цэцэрлэг	орны тоо	3125	1820	2170	4295	1580	10455	7857
Сургууль	суудлын тоо	11183	7280	8008	15070	3968	17110	8008
Дотуур байр	орны тоо	1000	1270	620	900	170	1580	788
Соёлын төв	суудлын тоо	2000	2320	1400	0	1050	4180	2826
Хүн эмнэлэг	орны тоо	445	460	545	110	60	348	24

Эх сурвалж: УАГ

Тайлант оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн дүнг салбараар нь авч үзвэл, нийгмийн салбарт 46.4 хувь буюу 720.7 тэрбум, дэд бүтцийн салбарт 30.9 хувь буюу 480.3 тэрбум, бусад салбарт 22.7 хувь буюу 352.4 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр хуваарилсан байна.

Хүснэгт 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын салбараар ангилсан судалгаа /тэрбум төгрөг/


Салбарын ангилал	2018 он		2019 он		Өмнөх жилтэй харьцуулахад өссөн, буурсан дүн
	Дүн	Хувь	Дүн	Хувь	
Дэд бүтэц	198.8	29.1	480.3	30.9	281.5
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт	262.8	38.5	616.5	39.7	353.7
Эрүүл мэнд	60.8	8.9	104.2	6.7	43.4
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	17.3	2.5	33.9	2.2	16.6
Төрийн төв байгууллагууд	59.4	8.7	214.8	13.8	155.4
Хууль сахиулах, батлан хамгаалах	42.0	6.1	58.4	3.8	16.4
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй	38.2	5.6	43.3	2.8	5.1
Хүнд үйлдвэр	4.0	0.6	2.0	0.1	(2.0)
Дүн	683.3	100.0	1,553.4	100.0	870.1

Эх сурвалж: УАГ, Сангийн яам

Хүснэгтээс үзэхэд, 2019 онд хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалт 1 дахин буурч, бусад салбарын хөрөнгө оруулалт 1.1-3.6 дахин нэмэгдсэн байна.



График 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийн судалгаа /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 91.9 хувьтай байгаа нь өмнөх таван жилтэй харьцуулахад хамгийн өндөр байна.



БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦООГ ГАЖУУДУУЛСНААС САЛБАРЫН БОДЛОГО АЛДАГДАХ, ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ БАТЛАХ ЗӨРЧИЛ ХЭВЭЭР БАЙНА

Монгол Улсын хөгжлийн дунд болон богино хугацааны бодлого, батлагдсан төсөв хоорондын уялдаа бүрэн хангагдахгүй байгаа нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна

1.1. Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т 2019 онд хэрэгжих 16 төсөл, хөтөлбөрт 365.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгаснаас Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд 9 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 19.7 тэрбум төгрөгөөр доогуур баталсан байна.

1.2. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 290 дүгээр тогтоолоор тодотгол хийж, төсөл, хөтөлбөрийн тоог 2-оор бууруулж, санхүүжүүлэх дүнг 198.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 5. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт батлагдсан 2019 онд улсын төсвөөс санхүүжих төсөл, хөтөлбөрт оруулсан тодотгол /тэрбум төгрөг/

Д/д	ТЭЗ	Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоол		Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолын тодотгол		Зөрүү нэмэгдсэн +/-, хасагдсан /-/	
		Төслийн тоо	Санхүүжих дүн	Төслийн тоо	Санхүүжих дүн	Төслийн тоо	Санхүүжих дүн
1	БСШУСС	3	209.8	3	458.2	0	248.4
2	ЗТХС	4	93.3	4	75.9	0	(17.4)
3	ЭМС	2	17.9	2	8.6	0	(9.3)
4	ЭХС	3	16.7	2	7.8	(1)	(8.9)
5	МУЕС	1	1.0	1	1.4	0	0.4
6	БХБС	2	25.5	1	7.5	(1)	(18.0)
7	ХЗДХС	0	0	1	3.9	1	3.9
8	НЗД бөгөөд УБХЗ	1	1.0	0	0	(1)	(1)
Нийт дүн		16	365.2	14	563.3	(2)	198.1

Эх сурвалж: Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр

1.3. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тодотголоор дараах өөрчлөлтийг оруулсан байна. Тухайлбал,

БСШУСС: Нэр бүхий 3-н төсөл, хөтөлбөрийн 2019 онд санхүүжих дүн 209.8 тэрбум төгрөг байсныг 458.2 тэрбум төгрөг болгож, 248.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн;

ЗТХС: “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал” төслийн нэмэлт санхүүжилт 15.0 тэрбум төгрөг хасагдаж, Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км авто замын санхүүжилт 0.7 тэрбум төгрөг нэмэгдсэн байна;

ЭХС: Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВт-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт (улсын хэмжээнд) төслийн 9.6 тэрбум төгрөг хасагдсан;

БХБС: Нийслэл, аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт (улсын хэмжээнд) төслийн 13.0 тэрбум төгрөг хасагдсан;

ХЗДХС: Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулах төслийн 3.9 тэрбум төгрөг нэмэгдсэн;

НЗД бөгөөд УБХЗ: Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төслийн 1.0 тэрбум төгрөг хасагдсан байна.

1.4. УИХ-ын 2018 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 33 төсөл, арга хэмжээг 455.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгаснаас Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд 18.9 тэрбум төгрөгөөр санхүүжих дүнтэй 8 төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна.

1.5. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9-д “Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна” гэж заасантай нийцэхгүй байна.



1.6. Монгол Улсын дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, тухайн оны төсвийн хууль хоорондын уялдаа бүрэн хангагдахгүй байгаа нь улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт хэрэгжихгүй байх эрсдэлийг дагуулж байна.

1.7. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1¹-д заасан хугацаанд ирүүлсэн ТЕЗ-дын саналд үндэслэн 2019 оны төсвийн хязгаарыг боловсруулж, мөн хуулийн 8.3.3²-т заасны дагуу Засгийн газрын 2018 оны 191 дүгээр тогтоолоор нийт 17 ТЕЗ-ийн хөрөнгийн зардлын хязгаарыг 1,564.6 тэрбум төгрөгөөр баталжээ.

1.8. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд дээрх төсвийн хязгаарт тусгагдаагүй 8 ТЕЗ-ийн 13.9 тэрбум, төсвийн хязгаараас давуулж 11 ТЕЗ-ийн 673.6 тэрбум төгрөгийн хөрөнгийн зардлыг баталсан байна.

Хүснэгт 6. Төсвийн хязгаарт хөрөнгийн зардал тусгагдаагүй болон хязгаараас давсан ТЕЗ-дын мэдээлэл /сая төгрөг/

Д/д	Төсвийн хязгаарт хөрөнгийн зардал тусгагдаагүй		Д/д	Төсвийн хязгаараас давсан	
	ТЕЗ	Зардлын дүн		ТЕЗ	Давсан зардлын дүн
1	МУИХД	2,000.0	1	ЗГХЭГД	27,899.0
2	АТГД	820.0	2	ГХС	2,630.0
3	ҮАБЗНБД	247.0	3	ХЗДХС	24,892.7
4	ҮХЦД	500.0	4	БОАЖС	1,007.7
5	УДШЕШ	4,000.0	5	БХС	12,533.9
6	МУЕА	1,500.0	6	БСШУСС	334,080.3
7	ШЕЗД	800.0	7	ЗТХС	149,069.5
8	СЕХД	4,000.0	8	ХНХС	17,980.0
			9	ЭМС	10,211.2
			10	ЭХС	30,951.0
			11	БХБС	62,364.7
Нийт		13,867.0	Нийт		673,620.0

Эх сурвалж: Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 191 дүгээр тогтоол

1.9. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг өмнөх онтой харьцуулж ангиллаар авч үзвэл,

Хүснэгт 7. Улсын төсвийн 2018, 2019 оны хөрөнгө оруулалтын харьцуулалт /тэрбум төгрөг/

Хөрөнгө оруулалтын ангилал		Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль			Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль			Зөрүү нэмэгдсэн +/-, хасагдсан -/-		
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүү жих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүү жих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүү жих дүн
Хөрөнгө оруулалт	Шинэ	456	928.3	385.2	659	1,621.4	836.6	203	693.0	451.4
	Үргэлжлэх	112	1,039.4	150.7	341	1,240.1	458.8	229	200.7	308.1
Их засвар	Шинэ	106	97.9	69.7	165	126.4	114.0	59	28.4	44.3
	Үргэлжлэх	1	7.5	2.5	27	52.2	25.1	26	44.7	22.6
Тоног төхөөрөмж	Шинэ	68	59.3	54.7	72	141.9	107.9	4	82.6	53.1
	Үргэлжлэх	1	8.1	3.1	4	11.9	4.7	3	3.8	1.6
ТЭЗҮ	Шинэ	5	19.1	17.4	12	4.6	4.6	7	(14.5)	(12.8)
	Үргэлжлэх	0	0	0	1	2.2	1.6	1	2.2	1.7
ДҮН	Шинэ	635	1,104.6	527.0	908	1,894.1	1,063.1	273	789.5	536.0
	Үргэлжлэх	114	1,055.0	156.3	373	1,306.4	490.2	259	251.4	334.0
НИЙТ		749	2,159.6	683.3	1281	3,200.5	1553.3	532	1,040.9	870.0

Эх сурвалж: Монгол Улсын 2018, 2019 оны төсвийн тухай хууль

1.10. Хуульд батлагдсан төсөл, арга хэмжээний 68.4 хувь буюу 1,063.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 908 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжих, 31.6 хувь буюу 490.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 373 төсөл, арга хэмжээ үргэлжлэн хэрэгжихээр байгааг өмнөх 2018 онтой харьцуулахад шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ 1.4 дахин, үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээ 3.3 дахин тус тус нэмэгдсэн байна.

¹ Төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх.

² Засгийн газар төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын төслийг хэлэлцэн жил бүрийн 7 дугаар сарын 01-ний дотор батлах.



Засгийн газар Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн саналд тусгагдаагүй 266 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд нэгтгэн Улсын Их Хуралд өргөн барьжээ

1.11. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3³-т заасны дагуу ТЕЗ-д 2019 оны төсвийн саналаа 2018 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлснийг мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4⁴, 8.4.5⁵-д заасны дагуу Сангийн яам нэгтгэн боловсруулж, Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

1.12. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төсөлд 24 ТЕЗ-аас нийт 2865 төсөл, арга хэмжээг 6,915.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх саналыг Сангийн яаманд хүргүүлснийг Засгийн газрын 2018 оны 191 дүгээр тогтоолоор баталсан ТЕЗ-дын 2019 оны хөрөнгийн зардлын төсвийн хязгаартай харьцуулахад 4.4 дахин их байна.

1.13. Энэ нь салбарын хэмжээний хөрөнгө оруулалтын бодлогогүй, төсөл, арга хэмжээг хэрэгцээ, шаардлага, үр ашгаар нь эрэмбэлэх төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлээгүй, эрх зүйн зохицуулалтыг чанд мөрддөггүйгээс шалтгаалан ТЕЗ-дын түвшинд тухайн онд батлагдсан төсвийн хязгаарыг баримтлахгүй байгааг харуулж байна.

1.14. Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам ТЕЗ-даас төсвийн саналд ирүүлсэн 5,728.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 2248 төсөл, арга хэмжээг хасаж, ТЕЗ-дын төсвийн саналд тусгаагүй 262.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 266 төсөл, арга хэмжээг нэмж УИХ-д өргөн барьжээ.

Хүснэгт 8. Төсвийн хязгаар, ТЕЗ-дын төсвийн санал, Сангийн яамнаас төсвийн төслийг нэгтгэж боловсруулсан байдлыг харьцуулсан үзүүлэлт /тоо, сая төгрөг/

Д/д	ТЕЗ	ТЕЗ-дын төсвийн батлагдсан хөрөнгийн зардлын хязгаар	ТЕЗ-даас Сангийн яаманд хүргүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ-ний төсвийн санал		ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын ТАХ-ний төсвийн саналыг Сангийн яамнаас нэгтгэсэн хувилбар		ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын ТАХ-ны төсвийн саналаас Сангийн яаманд хасагдсан		ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын ТАХ-ний төсвийн саналд тусгагдаагүй Сангийн яаманд нэмэгдсэн	
			ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн
1	МУИХД	-	2	3,071.1	-	-	2	3,071.1	-	-
2	МУЕС	174,717.7	53	61,817.8	2	7,231.2	47	57,423.7	-	-
3	МУШС	11,088.2	156	173,574.7	6	4,563.6	154	170,946.2	4	1,935.1
4	ЗГХЭГД	10,815.0	149	158,325.7	47	27,460.9	113	135,647.0	11	7,570.0
5	БОАЖС	12,768.5	170	182,363.1	10	7,300.0	164	174,963.1	4	2,200.0
6	ГХС	245.0	79	106,911.8	2	2,875.0	77	104,036.8	-	-
7	СС	630,151.1	303	385,081.3	11	146,386.3	296	265,845.0	4	27,150.0
8	ХЗДХС	17,990.7	124	196,152.8	31	40,838.7	101	159,309.1	8	3,995.0
9	ХНХС	15,915.4	87	155,302.8	23	23,757.8	77	143,602.8	13	12,057.8
10	БХС	2,965.8	17	317,195.7	6	15,499.7	12	72,466.7	-	-
11	БХБС	78,985.4	89	1,022,455.0	80	90,821.0	63	973,551.2	54	41,916.7
12	БСШУСС	282,373.4	944	2,160,321.3	446	476,798.8	595	1,747,047.0	97	63,524.3
13	ЗТХС	92,712.4	213	852,659.8	96	170,325.1	140	729,429.9	23	47,095.2
14	УУХҮС	33,335.9	11	11,341.6	1	2,000.0	10	9,341.6	-	-
15	ХХААХҮС	34,236.5	65	523,047.4	16	16,337.0	60	517,652.9	11	10,942.5
16	ЭХС	66,199.3	40	246,215.2	22	95,819.2	27	169,108.3	9	18,712.6
17	ЭМС	94,026.7	321	284,474.2	72	81,016.2	276	227,931.0	27	24,473.0
18	АТГД	-	4	1,659.6	1	820.0	3	839.6	-	-
19	МУЕА	-	3	4,597.7	1	1,500.0	1	2,897.7	-	-
20	МУЕП	6,110.0	14	9,110.0	1	1,400.4	13	8,000.0	-	-
21	ШЕЗД	-	9	37,489.3	1	800.0	9	37,489.3	1	800.0
22	УДШЕШ	-	8	21,826.5	2	4,000.0	4	17,826.5	-	-
23	ҮАБЗД	-	3	493.6	-	-	3	493.6	-	-
24	ЦАУЗБУК	-	1	10.6	-	-	1	10.6	-	-
Нийт дүн		1,564,637.0	2865	6,915,498.6	877	1,217,550.9	2248	5,728,930.7	266	262,372.2

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны 191 дүгээр тогтоол, Сангийн яам

1.15. ТЕЗ-дын төсвийн төсөлд тусгагдаагүй хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусган УИХ-д өргөн

³ Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

⁴ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 8.4.3-т заасан жилийн төсвийн саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт өргөн мэдүүлэх.

⁵ Засгийн газар жилийн төсвийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор УИХ-д өргөн мэдүүлэх.



барьсан нь салбарын бодлого алдагдах, төсөвлөлтийн шаардлага хангагдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үр дагавартай байна.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд төсөвлөлтийн шаардлага хангаагүй 538 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ

1.16. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 25 ТЕЗ-ийн төсвийн багцад батлагдсан 1281 төсөл, арга хэмжээнээс Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагатай шинээр хэрэгжүүлэх 638 төсөл, арга хэмжээ байна.

1.17. Үүнээс 15.7 хувь буюу 100 төсөл, арга хэмжээг хуульд тусгахдаа төсөвлөлтийн шаардлагыг хангасан, 69.1 хувь буюу 441 төсөл, арга хэмжээг хуульд туссаны дараа зураг төсвийг батлуулсан, 15.2 хувь буюу 97 төсөл, арга хэмжээний зураг төсвийг 2020 оны эхний хагас жилийн байдлаар батлаагүй байна.

Хүснэгт 9. Шинээр эхлүүлэх ТАХ-ний зураг төсөв баталгаажсан байдал /тоо, эзлэх хувь/

Д/д	ТЕЗ	Зураг, төсөв шаардлагатай шинээр хэрэгжих ТАХ-ний тоо	Үүнээс,		Хуульд тусгасны дараа зураг төсвийг нь батлуулсан ТАХ-ний		Зураг төсвөө батлуулаагүй ТАХ-ний	
			Хуульд тусгахын өмнө зураг, төсвийг нь батлуулсан ТАХ-ний		Хуульд тусгасны дараа зураг төсвийг нь батлуулсан ТАХ-ний		Зураг төсвөө батлуулаагүй ТАХ-ний	
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	ЗТХС	103	38	36.9	61	59.2	4	3.9
2	БОАЖС	14	1	7.1	6	42.9	7	50.0
3	ЭМС	47	2	4.3	38	80.8	7	14.9
4	ЭХС	16	3	18.8	12	75.0	1	6.2
5	ХНХС	22	-	-	7	31.8	15	68.2
6	БХБС	94	16	17.0	76	80.9	2	2.1
7	МУШС	3	2	66.7	1	33.3	-	-
8	ХХААХҮС	4	-	-	2	50.0	2	50.0
9	ШЕЗД	1	-	-	1	100.0	-	-
10	БХС	2	1	50.0	1	50.0	-	-
11	БСШУСС	272	28	10.3	208	76.5	36	13.2
12	ХЗДХС	11	6	54.5	5	45.5	-	-
13	ЗГХЭГД	45	3	6.7	19	42.2	23	51.1
14	СС	4	-	-	4	100.0	-	-
Нийт дүн		638	100	15.7	441	69.1	97	15.2

Эх сурвалж: УАГ

1.18. Төсвийн тухай хуульд зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталж байгаа нь нэг талаас, төсвийн төлөвлөлтийн зарчим алдагдсан, нөгөө талаас “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм” /БНБД 81-94-12/-ийн 4 дүгээр бүлгийн 4.10 дахь хэсэгт “Барилгын нэгдсэн төсвийн тооцоонд зураг төсөл хайгуулын ажлын зардал”-ыг тусгахаар заасантай холбоотой байна.

1.19. Өөрөөр хэлбэл, Зураг төсөл боловсруулж, магадлал хийлгэх үе шатны ажлын зардлыг барилга угсралтын ажлыг гүйцэтгэх үе шатны ажлын төсвийн бүрэлдэхүүнд баталж байгаа нь зураг төсөл боловсруулах үе шатанд санхүүжилт авах боломжгүйд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг салбарын бодлогын хүрээнд орон нутаг, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэх шаардлагатай байна

1.20. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчимд “нийгмийн үйлчилгээнд зарцуулж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг хүн амын тоотой уялдуулж төлөвлөх”-өөр заасан байна.

1.21. Монгол Улсын сум, дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн барилгын хүчин чадлыг нормативт хэмжээтэй (Ерөнхий боловсролын сургуулийн



барилгын төлөвлөлт БД 31-113-11)⁶, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын хүчин чадлыг суралцаж буй хүүхдийн тоотой⁷ харьцуулан үзэхэд:

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль:

- Барилгын хүчин чадал нормативт хэмжээнээс 159 сум, 4 дүүрэгт хэтэрсэн;
- Барилгын хүчин чадал нормативт хэмжээнээс 24 сум, 5 дүүрэгт доогуур;
- Барилгын хүчин чадал нормативт хэмжээтэй 148 суманд ойролцоо түвшинд байна.

Төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага:

- Суралцаж байгаа хүүхдийн тооноос барилгын хүчин чадал 10 суманд хэтэрсэн;
- Барилгын хүчин чадлаас суралцаж байгаа хүүхдийн тоо 168 сум, 8 дүүрэгт хэтэрсэн;
- Барилгын хүчин чадал суралцаж байгаа хүүхдийн тоотой 153 сум, 1 дүүрэгт ойролцоо түвшинд байна.

1.22. Дээрх үзүүлэлтээс харахад цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөх ерөнхий боловсролын сургуулийн барилгын хэрэгцээ, шаардлага нийслэлийн Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол дүүрэг болон 24 суманд, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгыг төлөвлөх хэрэгцээ, шаардлага нийслэлийн 8 дүүрэг, 168 суманд түлхүү байгаад анхаарлаа хандуулах шаардлагатай байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 5, 6-аас харна уу)

Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг баталснаас гүйцэтгэл удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болжээ

1.23. Барилгын зураг төсвийг иж бүрэн боловсруулж, магадлалаар баталгаажуулаагүй нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх үндсэн шалтгаан болж байна. Тухайлбал,

- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Булган, Бүрэгхангай сум/ ТАХ-ний зураг төсөв нь магадлалаар хянагдаагүй, барилгын зурагт гал тогооны зургийг орхигдуулсан;
- Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Богд сум/ ТАХ-ний гадна цахилгаан, холбоо дохиолол, дэд өртөө, гадна тохижилтын ажлыг төсөвт тусгаагүй;
- Цэцэрлэгийн барилга 280 ор /Баянхонгор, Баянхонгор сум/ ТАХ-ний гадна холболт, гадна хашааны ажлыг тусгаагүй;
- Цэцэрлэгийн барилга 150 ор /Дорнод, Баянтүмэн сум/ ТАХ-ний төсөвт 560.0 сая төгрөгийн уурын зуухны ажил тусгаагаагүй;
- Соёлын төвийн барилга 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/ ТАХ-ний төсөвт 362.0 сая төгрөгийн цахилгааны сүлжээ болон дотор, гадна сантехникийн шугамын ажил тусгаагаагүй;
- Эрүүл мэндийн төвийн барилга, 14 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/ ТАХ-ний зураг төсөвт гадна хашаа, гэрэлтүүлэг, гадна дулааны худаг хийх ажил тусгаагаагүй;
- Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж ТАХ-ний ажилд зайлшгүй хийх шаардлагатай хөрс тэгшлэх, нягтруулах ажил, хиймэл зүлгийн резинэн чигжээс хийх, явган хүний зам барих газрыг тэгшлэх шороон далангийн ажлыг төсөвт тусгаагүй орхигдуулсан байна.

1.24. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу газрын зөвшөөрөл гараагүй, техникийн нөхцөл олгогдоогүй байхад төсөл, арга хэмжээг хуульд тусгасан нь тайлант онд бүрэн хэрэгжүүлэх боломжгүйд хүргэсэн, инженер геологийн дүгнэлт, барилгын ажлын зөвшөөрөлгүйгээр барилга угсралтын ажлыг эхлүүлсэн зөрчил түгээмэл байна. Тухайлбал,

Газрын зөвшөөрөл олгогдоогүй ТАХ-ний тухайд:

- Багийн төвийн барилга /Архангай, Өндөр-Улаан сум, Хануй баг/
- Улаанбаатар хотод байршилтай 5 ТАХ;
- Татварын хэлтсийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/ ТАХ-ний газрын асуудлыг урьдчилан шийдээгүй, хуучин барилгыг акталж, уг газар дээр барилга барих шийдвэр оройтож гарснаар тайлант онд ашиглалтад ороогүй;

⁶ Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн барилгын хүчин чадлыг нормативт хэмжээтэй дараах байдлаар харьцуулсан. Үүнд: Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт БД 31-113-11 дүрмийн 1.3.5-д заасан 1000 хүн тутамд байвал зохих суудлын нормын доод хэмжээ 115 байна гэснийг шалгуур болгон сум, дүүргийн хүн амын тоонд хувааж нормативт суудлын тоог гарган, одоо ашиглагдаж байгаа барилгын хүчин чадалтай харьцуулж тооцоог гаргасан. Мөн ерөнхий боловсролын сургуулийн барилгын хүчин чадал нормативт хэмжээтэй ойролцоо гэдэг нь хүчин чадал ± 100 суудлын дотор хэлбэлзэж байхаар тооцсон болно.

⁷ Төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ашиглагдаж байгаа барилгын хүчин чадлыг суралцаж байгаа хүүхдийн тоотой дараах байдлаар харьцуулсан. Үүнд: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын хүчин чадлыг суралцаж байгаа хүүхдийн тоотой харьцуулж зөрүүг гарган ± 30 орны хооронд байвал ойролцоо түвшинд, түүнээс дээш, доош гарсныг хэтэрсэнээр тооцсон болно.



- Оюутны дотуур байрын барилга /Архангай, Батцэнгэл, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Хайрхан, Хотонт, Цэцэрлэг, Эрдэнэмандал сум/ ТАХ-ний газрын зөвшөөрөл, эзэмших эрхийн гэрчилгээ нь үйлчилгээний зориулалтаар хувь хүний нэр дээр олгогдсон газарт хэрэгжиж байна.
- Дотуур байрын барилга, 80 ор /Дорноговь, Эрдэнэ сум/ ТАХ-г 2013 онд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлсэн газар дээр барьсан бөгөөд тус газрын асуудлыг шийдвэрлээгүй;
- Булган аймгийн Сэлэнгэ суманд хээлтүүлэгч малын тэжээлийн байр, Бугат сум, Түлүүгийн давааны хээтээ тэнхлэгийн дагуу ХАА-н бүтээгдэхүүн борлуулах цэг барих ажлуудын газрын зөвшөөрөл олгогдоогүй байна.

Техникийн нөхцөл олгогдоогүй ТАХ-ний тухайд:

- Улаанбаатар хотод байршилтай 41 ТАХ;
- Чойрын хийдийн гол дуган, явган зам, тохижилт /Говьсүмбэр, Сүмбэр сум /
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Сайнцагаан сум, 1 дүгээр цэцэрлэг/

Инженер геологийн дүгнэлт гараагүй ажлын тухайд:

- Соёлын төвийн барилга, 300 суудал /Завхан, Их-Уул сум/
- Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Шилүүстэй сум/

Барилгын ажлын зөвшөөрөл гараагүй ажлын тухайд:

- Спорт заалны барилга /Говь-Алтай аймгийн Бигэр, Бугат, Есөнбулаг сумд, Цогт сумын Баянтоорой тосгон/

1.25. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” гэж заасан төсөвлөлтийн зарчмыг хангахгүйгээр санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталж байгаа нь хуулиар тодорхойлсон хугацаанд ТАХ ашиглалтад орохгүй байх эрсдэлтэй байна.

Хүснэгт 10. Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталсан ТАХ /сая төгрөг/

Д/д	ТАХ-ний нэр	Хэрэгжих хугацаа		Батлагдсан		Зөрүү	
		Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	ТАХ-г хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан байх хэмжээ	Тухайн онд баталсан тэнцүү хуваарилсан хэмжээний зөрүү
1	Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн оюутны дотуур байрын барилга /Улаанбаатар, Налайх/	2019	2020	12,500.0	2,500.0	6,250.0	(3,750.0)
2	Сургуулийн барилга, 1200 суудал /Улаанбаатар, ХУД/	2019	2020	7,200.0	2,661.0	3,600.0	(939.0)
3	Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, СБД/	2019	2020	6,040.0	2,000.0	3,020.0	(1,020.0)
4	Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2019	2020	7,850.0	2,000.0	3,925.0	(1,925.0)
5	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 10 дугаар хороо/	2019	2020	2,500.0	500.0	1,250.0	(750.0)
6	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо/	2019	2020	2,500.0	500.0	1,250.0	(750.0)
7	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо/	2019	2020	2,500.0	500.0	1,250.0	(750.0)
8	Дүүргийн соёлын ордны барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2019	2020	8,500.0	3,000.0	4,250.0	(1,250.0)
9	Шинжлэх ухааны академийн нэгдсэн байрын өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2019	2020	3,500.0	1,500.0	1,750.0	(250.0)
10	Сүрьеэгийн эмнэлгийн барилга /Улаанбаатар/	2019	2020	10,000.0	1,000.0	5,000.0	(4,000.0)
11	Эмнэлгийн барилга, 50 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 21 дүгээр хороо/	2019	2020	5,000.0	1,300.0	2,500.0	(1,200.0)
Нийт				68,090.0	17,461.0	34,045.0	(16,584.0)

Эх сурвалж: Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль

1.26. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар БХБС-ын төсвийн багцад баталсан төсөл, арга хэмжээнээс хөрөнгө оруулалтын бус шинжтэй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй төсөл, арга



хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн нь төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг алдагдуулсан байна.

Хүснэгт 11. Хөрөнгө оруулалтын бус шинжтэй ТАХ /сая төгрөг/

Д/д	ТАХ-ний нэр	Төрөл	Хугацаа		Төсөвт өртөг
			Эхлэх	Дуусах	
1	Орон сууцны байруудын дулаалга / УБ, БГД/	Их засвар	2019	2019	996.6
2	Орон сууцны байруудын дээврийн их засвар /УБ, БГД, 18, 19-р хороо/	Их засвар	2019	2019	200.0
3	Орон сууцны байруудын дулаалга / УБ, БГД/	Их засвар	2019	2019	1,000.0
4	Орон сууцны байруудын дээврийн их засвар / УБ, БГД/	Их засвар	2019	2019	500.0
5	Орон сууцны байруудын их засвар / УБ, БХД, 1-р хороо/	Их засвар	2019	2020	3,886.1
6	Орон сууцны байруудын цахилгаан шатны засвар / УБ, БГД/	Их засвар	2019	2019	300.0
7	Орон сууцуудын лифт шинэчлэлт УБ, СХД/, 29-р хороо, 22а, 22б, 23а дугаар байр/	Тоног төхөөрөмж	2019	2019	400.0
Нийт					7,282.7

Эх сурвалж: Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль

1.27. Өмнөх онуудад эхэлж он дамжин үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр хуульчилсан 89.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 58.4 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан 30 төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд тусгахгүйгээр орхигдуулсан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж, дуусаагүй орхигдсон барилга нэмэгдэх үр дагавартай байна. *(Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу)*

1.28. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуульд батлагдсан 186.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 58 төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд тусгахдаа төсөвт өртгийг нийт 96.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлжээ.

1.29. Төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний 24 буюу 41.4 хувь нь нэмэлт ажил гарснаас, 16 буюу 27.6 хувь нь хуульд зураг төсөвгүй туссанаас, 9 буюу 15.5 хувь нь төсвийн үнэлгээ нэмэгдсэнээс, 2 буюу 3.4 хувь нь хуульд иж бүрэн зураг төсөвгүй туссанаас, 7 буюу 12.1 хувь нь бусад асуудлаас тус тус шалтгаалсан байна. *(Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу)*

1.30. Дээрх байдлаас үзэхэд, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвлөлтийн талаарх төрийн байгууллагуудын ажлын уялдаа хангалтгүй, эрх зүйн чадамж, хариуцлага тооцох асуудал сул байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо алдагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд цахим системийг нэвтрүүлсэн байна

1.31. Сангийн яамнаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем www.publicinvestment.gov.mn веб хуудас болон гар утасны аппликейшн зэргийг ашиглалтад оруулж санхүүжилтийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох чиглэлээр арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах алхам болсон байна.

1.32. Дээрх арга хэмжээний эрх зүйн орчныг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”, 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-аар бүрдүүлсэн байна.

1.33. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд оролцогч талууд эрх зүйн зохицуулалтын дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цахим системийг үйл ажиллагаандаа ашиглах шаардлагатай байна.



БҮЛЭГ 2. УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 77.5 ХУВЬТАЙ БАЙНА

Худалдан авах ажиллагааг оройтож зохион байгуулснаас төсөл, арга хэмжээний гүйцэтгэл тайлант онд бүрэн хэрэгжихгүй байх эрсдэл үүсжээ

2.1. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 25 ТЕЗ-ийн төсвийн багцад 1,894.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,037.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 908 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталсан байна.


2.2. Засгийн газрын 2018 оны 388 дугаар тогтоолоор Монгол Улсын 2019 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас худалдан авах ажиллагааг нь зохион байгуулах 420.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 229.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 197 төсөл, арга хэмжээний жагсаалтыг нэгдүгээр, аймаг, нийслэл хэрэгжүүлэх 649.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 398.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 570 төсөл, арга хэмжээний жагсаалтыг хоёрдугаар, Ерөнхий гэрээгээр худалдан авах 2 төсөл, арга хэмжээний жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталж, хэрэгжилтийг зохион байгуулсан байна.

2.3. Тайлант хугацаанд шинээр хэрэгжүүлэх 908 төсөл, арга хэмжээний 830 буюу 91.4 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 36 буюу 4.0 хувийг харьцуулалтын аргаар, 20 буюу 2.2 хувийг гэрээ шууд байгуулах аргаар, 12 буюу 1.3 хувийг зөвлөх үйлчилгээний журмаар, 1 буюу 0.1 хувийг шууд худалдан авалтын аргаар тус тус зохион байгуулж, 5 буюу 0.5 хувийг тендер шалгаруулалт зохион байгуулах шаардлагагүй гэж үзэж, 4 буюу 0.4 хувьд нь худалдан авах ажиллагаа зарлаагүй байна.

2.4. Худалдан авах ажиллагааг зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа 897 төсөл, арга хэмжээ буюу 98.8 хувийг цахимаар зохион байгуулжээ.

2.5. Тайлант хугацаанд ТЕЗ-дын зохион байгуулсан худалдан авах ажиллагааны хугацааг сараар авч үзвэл, 2019 оны эхний хагас жилд 80.9 хувь, сүүлийн хагас жилд 19.1 хувьтай байна.

График 3. ТЕЗ-дын худалдан авах ажиллагаа зохион байгуулсан хугацаа /хувь, сараар/



Эх сурвалж: Сангийн яам

2.6. ТЕЗ-д улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 19.1 хувийн худалдан авах ажиллагааг сүүлийн хагас жилд зохион байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.8-д “барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх” гэж заасныг зөрчиж, төсөл, арга хэмжээ тайлант онд бүрэн хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.7. Мөн 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх шинээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой 91 гомдол Сангийн яаманд ирснийг хянаж, дараах шийдвэрийг гаргасан байна. Үүнд:



- *Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй 32 ТАН буюу 35.2 хувь;*
- *Үнэлгээг дахин хийлгэх 57 ТАН буюу 62.6 хувь;*
- *Тендер шалгаруулалтыг хүчингүй болгох 2 ТАН буюу 2.2 хувьтай байна.*

Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан Төсвийн ерөнхийлөн захирагчдад Сангийн яамнаас өгсөн дундаж үнэлгээ 73.2 хувьтай байна

2.8. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэгт заасны дагуу Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийг үндэслэн Сангийн яамнаас ТЕЗ-дын 2019 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн төлөвлөгөө, тендер шалгаруулалтын явц, цахим тендер шалгаруулалтын урилга, үр дүн болон гомдлын судалгаанд үндэслэн үнэлгээ өгсөн байна.

Хүснэгт 12. ТЕЗ нарын худалдан авах ажиллагаанд өгсөн үнэлгээ /хувиар/

Д/д	ТЕЗ	Худалдан авах ажиллагааны үнэлгээ					Д/д	ТЕЗ	Худалдан авах ажиллагааны үнэлгээ				
		2016 он	2017 он	2018 он	хувь	үнэлгээ			2016 он	2017 он	2018 он	хувь	үнэлгээ
1	БОАЖС	35.0	72.5	73.3	84.0	сайн	13	УЕП	80.0	41.7	63.5	74.0	хангалттай
2	ХХААХҮС	40.0	72.5	67.0	84.0	сайн	14	УУХҮС	66.9	84.8	73.3	71.0	хангалттай
3	ШЕЗД	64.0	88.1	73.9	84.0	сайн	15	ЭХС	46.0	68.9	58.8	71.0	хангалттай
4	УДШЕШ	80.0	73.8	80.0	83.0	сайн	16	МУЕС	27.0	75.0	83.8	70.0	хангалттай
5	ХЗДХС	51.5	84.3	86.0	81.0	сайн	17	СС	50.0	73.8	75.5	70.0	хангалттай
6	МУШС	38.0	75.0	74.4	80.0	сайн	18	ГХС	61.3	58.1	63.7	68.0	хангалттай
7	БХС	25.0	60.0	82.3	80.0	сайн	19	ЗТХС	33.0	92.0	81.6	67.0	хангалттай
8	АТГД	**	**	81.0	80.0	сайн	20	ҮХЦД	0	**	71.6	60.0	хангалттай
9	СЕХД	**	60.8	54.2	80.0	сайн	21	ХНХС	42.0	69.1	58.9	60.0	хангалттай
10	БХБС	23.0	59.6	48.5	79.0	хангалттай	22	МУЕА	46.0	0.0	60.0	60.0	хангалттай
11	ЗГХЭГД	27.0	77.1	82.7	78.0	хангалттай	23	БСШУСС	25.0	60.0	52.2	43.0	хангалтгүй
12	ЭМС	37.0	68.8	71.6	77.0	хангалттай							
		Дундаж хувь							44.9	70.8	70.3	73.2	

Эх сурвалж: Сангийн яам

2.9. Сангийн яамнаас 23 ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ өгөхөд 9 нь сайн буюу 80-84 хувь, 13 нь хангалттай буюу 60-79 хувь, 1 нь хангалтгүй буюу 43 хувийн үнэлгээ авч дунджаар 73.2 хувьтай үнэлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад үнэлгээний түвшин 2.9 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Магадлалаар баталгаажуулах төсөвт өртгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас үр ашиггүй зардал гарах эрсдэлийг үүсгэсэн байна

2.10. Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан 23 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон ажил гүйцэтгэх гэрээний дүнгээс магадлалаар баталгаажсан төсвийн дүн 3,269.0 сая төгрөгөөр бага байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 7-оос харна уу)

2.11. Энэ нь төсөл, арга хэмжээг магадлалаар баталгаажсан зураг төсөвгүйгээр, тойм дүнгээр төсөвт өртгийг баталж худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас шалтгаалсан бөгөөд цаашид улсын төсвөөс үр ашиггүй зардал гарах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлжээ.

2.12. Иймд харьяалах ТЕЗ нар болон Сангийн яам төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, гэрээний дүнг магадлалаар баталгаажсан төсвийн дүнтэй уялдуулан хянаж, зохион байгуулалтын арга хэмжээг авах зайлшгүй шаардлага үүссэн байна.

2.13. Зураг төсөл, газрын зөвшөөрөл иж бүрэн бус, төсөвт батлагдсан дүн, магадлалын дүн зөрүүтэй зэргээс шалтгаалж дараах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2019 онд зохион байгуулах, хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүсжээ. Тухайлбал,

БОАЖС:

- *Дарьганга зусланг орчин үеийн стандартад нийцсэн амралт, аялал жуулчлалын цогцолбор болгон шинэчлэх /Сүхбаатар, Дарьганга сум/*
- *Тэрхийн цагаан нуурын экосистемийг хамгаалах далан /Архангай, Тариат сум/*
- *Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Дорнод, Хэрлэн сум/*

**ЭМС:**

- Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн өргөтгөлийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/ - Хуульд 3,750.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан боловч Барилгын хөгжлийн төвийн 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн ЕД-1189/2019 дугаар бүхий магадлалын ерөнхий дүгнэлтээр нийт төсөвт өртгийг 8,514.0 сая төгрөгөөр хянаж баталгаажуулсан;
- Сүрьеэгийн эмнэлгийн барилга /Улаанбаатар/ - газрын зөвшөөрөл зургийн хэмжээнээс бага хэмжээтэй батлагдсан, магадлалын ерөнхий дүгнэлт баталгаажигч гараагүй, гүйцэтгэгч шалгараагүй;
- Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ - зураг төсөл хянагдаж магадлалаар баталгаажаагүй, худалдан авах ажиллагаа амжилтгүй болж, гүйцэтгэгч шалгараагүй.

ЭХС:

- Аймгийн төвийн уурын зуухны цахилгаан нөөц эх үүсвэр /Дизель генератор/ /Говьсүмбэр, Сүмбэр сум/ ТАХ батлагдсан зураг, төсөвгүй, харьяа орон нутгаас холбогдох материалыг ирүүлэхгүй удаашируулсан, ирүүлсэн техникийн тодорхойлолт нь чанарын шаардлага хангаагүй зэргээс шалтгаалан худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон. НТШ-ыг цахим хэлбэрээр 2 удаа зохион байгуулсан боловч нэг ч оролцогч тендер ирүүлээгүй тул хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1-т заасны дагуу гэрээ шууд байгуулах үнийн санал авах урилгыг 4 компанид хүргүүлсэн боловч санал ирээгүй;
- Хөшөөтийн уурхайгаас Ховд аймгийн Үенч сум хүртэл 35 кВ-ын ЦДАШ, Үенч дэд станцын өргөтгөл /Ховд, Үенч сум/ ТАХ батлагдсан зураг төсөвгүй, Засгийн газрын 2016 оны 180 дугаар тогтоолын дагуу "Алтай трест" ХХК гүйцэтгэгчээр шалгарч ажил хэрэгжиж эхэлсэн боловч санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй учир 2019 оны Төсвийн тухай хуульд туссан. ХАА-г зохион байгуулах явцад "Алтай трест" ХХК шүүхэд гомдол гаргаж ХАА зогссон;
- Тайширын УЦС-аас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/ ХАА-ны явцад гомдол гарч шүүхэд шилжсэн. Тухайн онд багтаж маргаан шийдвэрлэгдээгүй тул гүйцэтгэгч шалгараагүй.

2.14. Зарим төсөл, арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.2⁸-т заасан тендерийн хүчинтэй хугацаанд байгуулаагүй байна. Тухайлбал,

- Өрхийн эмнэлгүүдийн барилгын засвар, тоног төхөөрөмж, программ хангамж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг 6, 15, 18, 25, 26 дугаар хороо/ Багц 2, 3, 4, 5, 7, 8, 9, 10 – тендерийн нээлтийг 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдөр хийсэн, Сангийн яамны 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 6-1/5767 дугаар албан бичгээр тендерийн хүчинтэй хугацааг 15 хоногоор сунгасан хэдий ч тендерийн хүчинтэй хугацаа 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр дууссан байхад 2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр гэрээ байгуулсан.
- Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ - Багц 4 шалгарсан Сетунари ХХК-д гэрээ байгуулах тухай мэдэгдлийг 2019 оны 12 дугаар сарын 24-ний хүргүүлсэн боловч 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдөр гэрээ байгуулсан,
- Өрхийн эмнэлгүүдийн барилгын засвар, тоног төхөөрөмж, программ хангамж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг 6, 15, 18, 25, 26 дугаар хороо/ Багц 1 шалгарсан Эй Кэй Юу ХХК-д гэрээ байгуулах тухай мэдэгдлийг 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлсэн боловч 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдөр гэрээ байгуулсан.

2.15. Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг"-ийн гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй байх хугацааг хоёрдмол утгагүй, тодорхой болгох шаардлагатай байна. Тухайлбал,

- "Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш ... **логноо оруулах**/ хугацаанд хүчинтэй байна." гэж зааснаас шалтгаалан:
 - Зарим ажлын хувьд гүйцэтгэгчийн ирүүлсэн гүйцэтгэлийн баталгаа ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй;
 - Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Сэлэнгэ, Хүдэр сум/ - гүйцэтгэгч Мэргэн дэнзэн ХХК-ийн ирүүлсэн гүйцэтгэлийн баталгаа нь огноо заасан буюу 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хүчинтэй;
 - Эрүүл мэндийн төвийн барилга /Говь-Алтай, Халиун сум/ - гүйцэтгэгч Арвин бэлт ХХК-ийн ирүүлсэн гүйцэтгэлийн баталгаа нь огноо заасан буюу 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хүчинтэй;
 - Сум дундын эмнэлгийн барилга /Дундговь, Эрдэнэдалай сум/ - гүйцэтгэгч "Төсөв төсөл" ХХК-ийн ирүүлсэн гүйцэтгэлийн баталгаа нь огноо заасан буюу 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдөр хүртэл хүчинтэй байгаа нь ажил дуусах хугацаанаас өмнө дууссан байна.

2.16. Орон нутагт эрх шилжин зохион байгуулагдсан зарим худалдан авах ажиллагаагаар шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсан нь Сангийн сайдын

⁸ Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.



2014 оны 212 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 5.2.4⁹-д заасныг зөрчсөн байна. Тухайлбал,

Архангай:

- Хуулийн XII.1.1.202 дугаартай “Оюутны дотуур байрын барилга /Архангай, Батцэнгэл, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Хайрхан, Хотонт, Цэцэрлэг, Эрдэнэмандал сум/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2 удаа зарлахад хоёуланд нь шаардлага хангаагүй гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн “Баянгийн эх” ХХК-тай аймгийн Засаг даргын 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн ...дугаартай захирамжаар гэрээг шууд байгуулсан нь ТБОНӨХБАҮХТХ-ийн 34.2-т заасныг зөрчсөн тул аймаг дахь ТАГ-аас Цагдаагийн газарт шилжүүлэн шалгуулах хүсэлт гаргасан.
- Архангай аймгийн Цахир суманд 320 суудалтай сургууль барих төслийн ТШӨХ-ийн ТӨӨЗ 6.2-т “магадлалаар баталгаажсан зураг төсөлтэй байх” гэж заасан боловч зураг төсөл боловсруулах гэрээтэй гэх “Лорд скай”, “Бөртэ”, “И Би Си” ХХК-уудын түншлэлийг шалгаруулсан;
- Үндсэн ажилтнуудынхаа НДШ-ийг төлөөгүй “Ар дэн” ХХК-ийг Өндөр-Улаан сумын Соёлын төвийн барилгын их засварын ажлын, “Нуурын толгой” ХХК-ийг Жаргалант сумын ЭМХ-ийн барилгын их засварын ажлын, “Гичгэнэ хяр” ХХК-ийг Өндөр-Улаан сумын Хануй багийн төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр тус тус шалгаруулсан;

Говьсүмбэр:

- Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн дагуу үнэлгээ хийгээгүйгээс БХБС-ын төсвийн багцад батлагдсан “Аймгийн төвийн дугуйн зам” төслийн тендер шалгаруулалтын явцад 1 удаа, “2 дугаар багийн гэр хорооллын цэвэр усны шугамд холбох”, “Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх” ажилд 2 удаа тус тус гомдол гарч тендер хүчинтэй байх хугацааг 30-45 хоногоор сунгаж, хугацаа алдсан.

Дархан-Уул:

- Дархан сумын 9, 10 дугаар багийн авто замын ус зайлуулах сүвгийн ажилд шалгарсан “Дөлгөөн дөхөм” ХХК нь ТӨӨЗ-ын 5.36¹⁰, 5.36¹¹, 5.36¹², 14.1ж¹³-д заасныг хангаагүй байхад үнэлгээний хорооны гишүүдийн 80 хувь нь дэмжсэн;
- Дархан сумын 10, 11, 12, 13, 14, 16 дугаар багийн нийтийн эзэмшлийн байруудын засвар, тохижилтын ажилд шалгарсан “Болор эрхэст цамхаг” ХХК нь ТӨӨЗ-ын 5.3а¹⁴-д заасан шаардлагыг хангаагүй;

Улаанбаатар:

- БГД-ээс зохион байгуулсан 1,378.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Архивын хэлтсийн барилга /20 дугаар хороо/ төсөл, арга хэмжээний ТББ-ийн ТШӨХ 6.3(в)-т голлох инженер техникийн ажилтнуудын ажилласан туршлагыг 1 жилээр тусгасан;
- Нийслэлийн ХААГ-аас зохион байгуулсан 240 ортой, цэцэрлэгийн барилга барих 4 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид тавигдах шаардлагыг харилцан адилгүй тодорхойлсон;

Ховд:

- Эрдэнэбүрэн сумын Тамгын газрын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр ХАБЭ ажилтны НДШ төлөөгүй “Цагаан бөлбөө” ХХК-ийг шалгаруулсан;

Сүхбаатар:

- Түмэнцогт сумын цэвэрлэх байгууламжийн их засварын ажлын ТШӨХ-д “Сүүлийн жил ашигтай ажилласан байх” гэж заасан боловч ашигтай ажиллаагүй “Дөрвөлж” ОНӨҮГ-ыг шалгаруулсан;

Өвөрхангай:

- Багийн өвсний фонд 3-ыг барих /Уянга суманд 2, Хархорин суманд 1/ 45.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөлд ажлын тоо хэмжээ, хяналтын төсөвгүйгээр тендерийг зарлаж, төсөвтөө дээвэр, шалны ажлыг тусгаагүй 38.8 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Эм Би Би” ХХК-ийг шалгаруулсан. “Эм Би Би” ХХК-ийн тусгай зөвшөөрөл нь дууссан бөгөөд тендерийн материалд “Гуулин тал” ХХК-ийн тодорхойлолтыг хавсаргасан;
- Багийн төвийн тоног төхөөрөмжийн шинэчлэл 119.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж нийлүүлэх тендер 98.0 сая төгрөгийн үнийн саналаар шалгарсан “Арвайхээр өргөө” ХХК нь “ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх, түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна” гэсэн шаардлагыг хангаагүй, нийлүүлэх барааны марк, үзүүлэлт, тоо хэмжээ, үнийн дүн зэргийг ирүүлээгүй байхад шалгаруулсан;
- Цаг уурын станцын барилга /Богд сум/ 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд ТШӨХ-ийн ТӨӨЗ 5.3-т заасан шаардлагуудыг хангаагүй “Шоо констракшн” ХХК-ийг шалгаруулсан;

⁹ Тендерийг үнэлэхэд холбогдох хууль болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан заавар, аргачлал, захиалагчийн боловсруулсан тухайн тендерийн баримт бичгийг баримтлах

¹⁰ Ижил төстэй ажил ядаж нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын аль нэг жилд төсөвт өртгийн 80 хувиас доошгүй өртөгтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн

¹¹ Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизм

¹² Ерөнхий инженер нь гэрээнд заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх хугацаа: 3 жил

¹³ Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг ирүүлнэ: НДШ төлөлтийн НД7, НД8 маягтыг сүүлийн 12 сараар ирүүлэх

¹⁴ Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлого төсөвт өртгийн 60 хувиас багагүй байна.



- Цэцэрлэгийн барилга, 75 ор /Хархорин сум/ 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд ТШӨХ-ийн ТӨӨЗ 5.2, 5.3-т заасан шаардлагыг хангаагүй "Хангай-Энержи" ХХК-ийг шалгаруулсан байна.

2.17. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд ЭМС-ын багцад батлагдсан "Төрөх эмнэлэг, 50 ор /Дорноговь, Сайншанд сум/ төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа "Дорноговь аймгийн Сайншанд сумын 50 ортой эмнэлгийн барилга угсралтын үлдэгдэл ажил" гэж хуулийн нэршлийг өөрчилж зарласан байна.

2.18. Түүнчлэн хуульд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүйгээс уул уурхайн олборлолт явуулж буй компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт хийсэн бүтээн байгуулалтад хөрөнгө төлөвлөх, төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 15 хувиас давсан байхад худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтыг зөрчсөн байна. Тухайлбал,

- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэлийн 1.1-д Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар төсөвт өртөг нь нэмэгдэж батлагдсан, барилга угсралтын ажил нь хоёр жилээс дээш хугацаанд хэрэгжих байгаа болон 30 ба түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний ажлын үнэд тохируулга хийх аргаар хугацаа сунгах гэрээг барилгын ажлын гүйцэтгэгч нартай байгуулахыг БСШУСС-д даалгасан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-т заасныг зөрчсөн байна.
- "Монголын алт" ХХК өөрийн хөрөнгөөр 2011 онд Өмнөговь аймгийн Гурвантэс суманд барьсан 800.0 сая төгрөгийн өртөг бүхий 320 суудалтай сургууль, 1,220.0 сая төгрөгийн өртөг бүхий 120 хүүхдийн дотуур байрны барилгыг 2016 онд Өмнөговь аймгийн ЗДТГ-т хүлээлгэн өгсөн байна. Гэвч Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд "Гурвантэс сумын дотуур байрны барилга худалдан авах" төсөл, арга хэмжээг 2,400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 500.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй шинээр хэрэгжүүлэхээр тусгасан;
- Баянхонгор аймгийн Эрдэнэцогт суманд 2018 оноос үргэлжлэн хэрэгжсэн ЗДТГ-ын барилгын төсөвт өртөг ашиглагчийн хүсэлтээр нэмж барьсан зоорийн давхар, ус, ариутгах татуургын холболтын зардал 420.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь анх батлагдсан төсөвт өртөгөөс 15 хувиас давсан тул гүйцэтгэгчийг оролцуулан худалдан авах ажиллагаа зохион байгуулсан гэх баримт бүрдүүлсэн.

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт 77.5 хувьтай байна

2.19. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 25 ТЕЗ-ийн төсвийн багцад 3,200.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 1,553.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1281 төсөл, арга хэмжээнд олгосон санхүүжилтийн гүйцэтгэл 1,422.6 тэрбум төгрөг буюу 91.6 хувь, зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 130.8 тэрбум төгрөг буюу 8.4 хувьтай гэж Сангийн яамнаас тайлагнасан байна.

2.20. Аудитаар санхүүжилтийн гүйцэтгэлийг хянаж үзэхэд 1,203.1 тэрбум төгрөг буюу 77.5 хувийг бодит ажлын гүйцэтгэлд, Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу 159.7 тэрбум төгрөг буюу 10.3 хувийг 10 ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, 59.8 тэрбум төгрөг буюу 3.8 хувийг банкны баталгаанд үндэслэж тус тус олгосон байна.

Хүснэгт 13. Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон барьцаа хөрөнгийн дансаар олгосон санхүүжилтийн дүн /сая төгрөг/

Д/д	ТЕЗ	Урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгосон			Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан		
		ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	Урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгосон дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан дүн
1	ЗГХЭГД	6	4,330.0	1,367.2	9	6,635.0	2,879.8
2	СС	3	106,536.3	9,386.5	7	125,986.3	35,013.0
3	ЭМС	15	15,807.6	10,621.6	22	33,751.9	17,249.6
4	БХБС	19	17,613.5	3,258.0	21	19,376.5	3,421.7
5	БСШУСС	74	94,995.9	26,584.6	131	162,674.3	58,951.0
6	ЗТХС	9	16,061.5	4,194.4	39	47,463.3	26,991.0
7	ХХААХҮС	5	4,400.0	1,762.2	12	12,536.3	3,899.6
8	ЭХС	3	14,070.0	1,397.8	4	8,473.9	3,497.1
9	ХНХС	6	4,500.0	1,275.4	13	16,747.0	5,581.9



10	ХЗДХС	1	350.0	62.4	-	-	-
11	БОАЖС	-	-	-	3	2,900.0	2,189.3
	Дүн	141	278,664.8	59,910.1	261	436,544.5	159,673.9

Эх сурвалж: Сангийн яам

2.21. Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолоор Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан банкны баталгааг үндэслэн олгох, зарим зайлшгүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулахаар ТЕЗ нарт даалгажээ.

2.22. Дээрх тогтоолоор төсөл, арга хэмжээний үе шатны ажлын санхүүжилтийг ТЕЗ нарын барьцаа хөрөнгийн зориулалтын бус дансанд он дамжуулан байршуулахыг ТЕЗ нарт даалгаж байгаа нь данс, бүртгэлийн тогтолцоо алдагдах эрсдэлийг үүсгэж байна.

2.23. ЗТХС-ын барьцаа хөрөнгийн дансанд төсөл, арга хэмжээний 2019 оны санхүүжилтээс Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2-т “Зарцуулах эрх нь дараагийн төсвийн жилд дамжсан, энэ хуулийн 43.1.3-т зааснаас бусад төсвийн нийт дүн нь төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн гурван хувиас хэтрэхгүй бөгөөд түүнээс давсан хэсгийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасныг зөрчиж ТЕЗ-ийн тухайн жилийн төсвийн гурван хувиас 14.5 тэрбум төгрөгөөр давсан дүнгээр он дамжуулан байршуулсан байна.

2.24. Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолын 1.2-т “банкны баталгааг үндэслэн олгосон санхүүжилт болон барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн дотор Сангийн яаманд хүргүүлж, тус яамны зөвшөөрлөөр чөлөөлөх” гэж заасан хэдий ч зарим гүйцэтгэгчдийн ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааны хүчинтэй хугацаа уг тогтоолд зааснаас богино байгаа тул баталгааны хугацаанд барилга, угсралтын ажлыг гүйцэтгүүлж, тогтоолын хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна. Тухайлбал,

БСШУСЯ:

- Дотуур байрын барилгын өргөтгөл /Увс, Тэс сум/ - гүйцэтгэгч “Зоос импекс” ХХК-ийн ирүүлсэн 107.4 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа 2020 оны 03 дугаар сарын 29-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр;
- Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо/ - гүйцэтгэгч “Синчи ойл” ХХК-ийн ирүүлсэн 52.1 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийг дуустал хүчин төгөлдөр;
- Сургуулийн барилга, 320 суудал /Өмнөговь, Номгон сум/ - гүйцэтгэгч “Өгөөмөрбаян дэнж” ХХК-ийн ирүүлсэн 56.4 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр;
- Соёлын төвийн барилга, 150 суудал /Говь-Алтай, Цээл сум/ - гүйцэтгэгч “Уран-Охид” ХХК-ийн ирүүлсэн 254.7 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хүчин төгөлдөр;
- Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Баруун-Урт сум/ - гүйцэтгэгч “Наран булаг трейд” ХХК-ийн ирүүлсэн 86.4 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр;
- Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум, Согоот баг, 4 дүгээр цэцэрлэг/ - гүйцэтгэгч “Жам” ХХК-ийн ирүүлсэн 684.6 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр;
- Дотуур байрын барилга, 75 ор /Төв, Баян сум/ - гүйцэтгэгч “Төв цогт өлзийт” ХХК-ийн ирүүлсэн 245.7 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр;

ЭМЯ:

- Эрүүл мэндийн төвийн барилга /Хөвсгөл, Эрдэнэбулган сум/ - гүйцэтгэгч “Юувоку” ХХК-ийн ирүүлсэн 628.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

ХНХЯ:

- Оюутны дотуур байрын барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/ - гүйцэтгэгч “Амарсанаа” ХХК-ийн ирүүлсэн 662.3 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр;

ХХААХҮЯ:

- Аймгийн мал эмнэлгийн байр /Архангай, Эрдэнэбулган сум/ - гүйцэтгэгч “Жам” ХХК-ийн ирүүлсэн 279.8 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр;

БХБЯ:



- Орон сууцын байруудын дээвэр, гадна фасад засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7, 8, 10 дугаар хороо, 18, 22, 26, 41, 43, 46 дугаар байр/ - гүйцэтгэгч “Эе эв” ХХК-ийн ирүүлсэн 116.2 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

Засгийн газрын 2018 оны “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 386 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна

2.25. Засгийн газрын 2018 оны 386 дугаар тогтоолоор Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг банкны баталгааг үндэслэн олгож, санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавьж төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг баталгаажуулан 2019 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн дотор Сангийн яаманд хүргүүлж, тус яамны зөвшөөрлөөр банкны баталгааг чөлөөлөх зохицуулалт хийсэн байна.

2.26. Дээрх тогтоолын хүрээнд 12 ТЕЗ төсвийн багцад батлагдсан 607.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 215.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 138 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч байгууллагад 70.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банкны баталгаанд үндэслэн олгожээ.

2.27. Аудитаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад БСШУСС, БХБС-ын 2018 оны төсвийн багцад батлагдсан 83.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 4 төсөл, арга хэмжээнд банкны баталгаагаар олгосон 3.1 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэлийг гаргаагүй, тогтоолын хэрэгжилтийг хангуулаагүй байна.

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хуульд батлуулснаас хөрөнгийн зохицуулалт хийх шаардлага үүссэн байна

2.28. Засгийн газрын 2019 оны 249 дүгээр тогтоолоор Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан ТЕЗ-ийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэхийг ТЕЗ нарт даалгасны дагуу 6 ТЕЗ төсвийн багцдаа батлагдсан 148 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 58.9 тэрбум төгрөгийн зохицуулалт хийсэн байна.

Хүснэгт 14. ТЕЗ-дын 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зохицуулалт хийсэн хөрөнгийн зардлын дүн /сая төгрөг/

Д/д	ТЕЗ	Санхүүжих дүн хасагдсан ТАХ-ний			Санхүүжих дүн нэмэгдсэн ТАХ-ний		
		Тоо	Хуулиар батлагдсан санхүүжих дүн	Зохицуулалтаар хасагдсан дүн	Тоо	Хуулиар батлагдсан санхүүжих дүн	Зохицуулалтаар нэмэгдсэн дүн
1	ХЗДХС	7	9,066.0	424.7	1	1,000.0	424.7
2	ХНХС	2	3,200.0	1,500.0	2	800.0	1,500.0
3	БХБС	73	56,169.8	19,279.1	9	28,500.0	19,279.1
4	БСШУСС	26	32,668.8	23,929.6	18	24,087.6	23,929.6
5	ЭХС	2	8,504.8	8,084.0	2	11,080.3	8,084.0
6	ЭМС	4	8,500.0	5,724.1	2	4,000.0	5,724.1
Дүн		114	118,109.4	58,941.5	34	69,467.9	58,941.5

Эх сурвалж: Сангийн яам

2.29. Дээрх ТЕЗ нар хөрөнгийн зохицуулалтыг хийхдээ 114 төсөл, арга хэмжээний 118.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээс 58.9 тэрбум төгрөгийг 34 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд шилжүүлснээр 2019 онд 17 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжих боломж бүрджээ.

2.30. Харин газрын асуудал бүрэн шийдэгдээгүй, худалдан авах ажиллагаа оройтсон, зураг төсөвгүй батлагдсан ажлуудын зураг төсвийг боловсруулж магадлалаар баталгаажуулахад хугацаа алдсан, төсвийн жилд багтаан гэрээ байгуулах боломжгүй болсон зэрэг шалтгаанаар 114 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг бууруулан хөрөнгийн зохицуулалт хийсэн байна.



Барилга угсралтын үе шатны ажилд зохиогчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт зөрчигдөж байна

2.31. БСШУСС, ЭМС, БХБС-ын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд зохиогчийн хяналт хийх гэрээг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ байгуулж, ажлын үр дүнг дүгнэж, санхүүжилтийг олгож байна.

2.32. Энэ нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.1-д “Захиалагч нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүргээс гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ”, 3.1.4-т “Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээг байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техник хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах”, БХБС-ын 2015 оны 185 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 2.1-д “Зураг төсөл зохиогч барилгын захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина” гэж заасныг тус тус зөрчиж байна.

2.33. Төсөл, арга хэмжээний зураг, төсөл зохиосон зардлыг барилга, угсралтын ажлын төсөвт өртгийн бүрэлдэхүүнд оруулан, төслийн хэрэгжилтийн явцад санхүүжүүлж байгаагаас эрх шилжсэн төсөл, арга хэмжээний зураг төслийн зардлыг давхардуулан олгосон зөрчил гарсан байна. Тухайлбал,

ЗТХС:

- Төв аймгийн “Борнуур сумын Шавартайн голын 39.8 у/м төмөр бетон гүүрний их засвар, шинэчлэлт”-ийн ажлын зураг, төсвийг “ГБЭТ” ХХК 40.0 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгэсэн зураг, төсвийн ажлын санхүүжилтийг аймгийн ЗДТГ-ын данснаас 2018 онд олгосон байхад ЗТХЯ-ны хөрөнгө оруулалтын зардлын данснаас дахин санхүүжүүлсэн.

БСШУСС:

- Төв аймгийн Лүн сумын 450 суудалтай спорт цогцолборын барилгын зураг төслийг зохиогч “Эм эс эл” ХХК-д зургийн үнэ 32.6 сая төгрөгийг 2019 онд ЗДТГ-аас олгосон байхад БСШУСЯ-ны эрх шилжсэн хөрөнгө оруулалтын данснаас давхардуулан санхүүжүүлсэн байна.

2.34. Цаашид захиалагч барилга угсралтын ажилд зохиогчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээг зураг төсөл зохиогч компанитай байгуулж, зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэн гэрээний хэрэгжилтийг хангуулж, барилга угсралтын ажлын үе шат бүрд дүгнэлт гаргуулж, үр дүнг тооцон зохих санхүүжилтийг олгож байх шаардлагатай байна.

2.35. Захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй байгууллагын зүгээс байнгын ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтэд тавих хяналт хангалтгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2¹⁵, 46.3¹⁶, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.7¹⁷, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын 1.3¹⁸-т заасныг тус тус зөрчсөн байна. Тухайлбал,

Архангай:

- Мал угаалгын онгоц, төмөр хашаа /Архангай, Булган, Жаргалант, Ихтамир, Өндөр-Улаан, Тариат, Хангай, Цахир, Чулуут сум, багууд/ ТАХ-ний гүйцэтгэгч “Урал их” ХХК нь бохирын цоногийг бетонодоогүй, хашаалаагүй зэрэг 8 ажлын гүйцэтгэлийг дутуу хийсэн;
- Засаг даргын Тамгын газрын барилга /Архангай, Төвшрүүлэх сум/ ТАХ-ний гүйцэтгэгч “Бридж констракшн” ХХК гадна тохижилт, ус зайлуулах шугамын ажлыг дутуу хийсэн, ашиглалтын явцад гомдол гаргасан;

¹⁵ Энэ хуулийн 33.1.18-д заасан журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх;

¹⁶ Хөрөнгө оруулагч, захиалагч ашиглалтад оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын явцад захиалагч, зохиогч, улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын чанар, аюулгүй байдлын талаар гаргасан дүгнэлт, ашиглалтад оруулсан баримт бичгийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш 30 өдөрт багтаан холбогдох архивт шилжүүлнэ.

¹⁷ Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг 14 хоногт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.

¹⁸ Барилга байгууламжийн хувийн хэрэг нь тухайн барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд хийгдсэн өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэл, их засварын ажил, үзлэг шалгалт, гарсан эвдрэл, гэмтэл, согогийн талаарх мэдээлэл, уг барилга байгууламжийн үндсэн үзүүлэлтийг агуулсан баримт бичиг байна.



- Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 50 ор /Архангай, Булган сум/ ТАХ-ний гүйцэтгэгч “Эсгэл” ХХК нь улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлээгүй, барилгын паркетан шал хөөж овойсон;
- Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Архангай, Жаргалант сум/ ТАХ-ний гүйцэтгэгч “Нуурын толгой” ХХК-ийн хийсэн агааржуулалтын хоолой ажилладаггүй, шал хазгай гэсэн гомдлыг ашиглагч байгууллагаас ирүүлсэн;

Говь-Алтай:

- “Сойл инженеринг” ХХК-ийн гүйцэтгэсэн Шарга сумын гүний худаг цахилгаанд холбогдоогүй, Халиун сумын гүний худгаас ус гараагүй, Алтай суманд өрөмдлөг хийгээд орхисон;

Говьсүмбэр:

- “Найрамдал хотхоны байрнуудын гадна зогсоол”-ын ажлыг гүйцэтгэгч компани хугацаандаа гүйцэтгэсэн боловч ажлын тоо хэмжээнд тусгасан ажлуудыг бүрэн хийгээгүй;
- “Аймгийн төвийн дугуйн зам”-ын болон нэгдсэн эмнэлгийн барилгын ажлаас шалтгаалан холболт хийгдээгүй байхад “Нэгдсэн эмнэлгийн барилгын газардуулга, генераторын барилга”-ыг улсын комисс хүлээн авсан;

Баян-Өлгий:

- Цагаан гол, долоон гаталгын модон гүүр, сайжруулсан зам, 2 км /Баян-Өлгий, Цэнгэл сум/ ТАХ-г улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан боловч зам эвдэрсэн, чулуугаар өрж хийсэн шүүлтүүр цооногууд нь нурсан, ашиглах боломжгүй болсон;

Дундговь:

- Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засварын зарим ажлыг өөрчлөн гүйцэтгэсэн боловч гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулаагүй, бетон цутгалтын далд ажлын актыг үйлдээгүй, архивд хүлээлгэн өгөх баримтыг бүрдүүлэх, гадна цонхны усны хаялга хийх зэрэг үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй;

Завхан:

- Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Завхан, Сонгино сум/ ТАХ-ний гүйцэтгэгчид байнгын ашиглалтад оруулах комиссоос өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс ашиглалт хангалтгүй байна.

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний 7.7 хувь буюу 98 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 14.4 хувь буюу 184 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дутуу байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна

2.36. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 25 ТЕЗ-ийн төсвийн багцад 3,200.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,553.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1281 төсөл, арга хэмжээнээс 2,572.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,213.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 999 нь бүрэн хэрэгжсэн, 341.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 207.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 184 нь хэрэгжилт дутуу, 287.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 132.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 98 нь хэрэгжээгүй байна.

2.37. Хэрэгжилт дутуу төсөл, арга хэмжээний 10.9 хувь буюу 20 нь гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас, 0.5 хувь буюу 1 нь санхүүжилт хугацаандаа олгогдоогүйгээс, 10.3 хувь буюу 19 нь зураг төсөвт өөрчлөлт орж, дахин магадлал хийлгэж хугацаа алдсанаас, 16.8 хувь буюу 31 нь гадна инженерийн дэд бүтэц шийдэгдээгүйгээс, 61.4 хувь буюу 113 нь ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан хугацаанд хэрэгжих боломжгүйгээс тус тус шалтгаалжээ.

2.38. Хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний 11.2 хувь буюу 11 нь ХАА зохион байгуулагдаагүйгээс, 19.4 хувь буюу 19 нь ХАА хүчингүй болсноос, 44.9 хувь буюу 44 нь ХАА хийгдсэн боловч ажил эхлээгүйгээс, 3.1 хувь буюу 3 нь гүйцэтгэгч ажлаа хугацаандаа хийгээгүйгээс, 2.0 хувь буюу 2 нь шаардлагагүй арга хэмжээ төлөвлөснөөс, 19.4 хувь буюу 19 нь бусад асуудлаас тус тус шалтгаалсан байна.

Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлээр 127.0 тэрбум төгрөгийн 265 зөрчил илэрсэн нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна

2.39. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасны дагуу ТЕЗ нар төсвийн төвлөрүүлэн болон харьяалах төсвийн шууд захирагч нарт тайлант онд 1,397.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 754.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 759 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах эрхийг шилжүүлжээ.



2.40. Нийт эрх шилжсэн 759 төсөл, арга хэмжээний 292.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 128 нь үргэлжлэх, 1,104.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 631 нь шинээр хэрэгжихээр батлагдсан байна.

2.41. Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний 91.4 хувь буюу 625 төсөл, арга хэмжээний эрхийг Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлагнах журам”-ын 2.13¹⁹ дах хэсэгт заасныг зөрчиж, 60-аас дээш хоногийн дараа шилжүүлжээ.

2.42. Энэ нь 362 төсөл, арга хэмжээний үнэлгээний хороог хугацаа хоцорч байгуулах, 213 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг төлөвлөсөн хугацаанаас 46-100 хоногоор, 115 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 101-ээс дээш хоногоор хоцорч зохион байгуулахад хүргэж, хэрэгжилт удаашрахад нөлөөлсөн байна. Тухайлбал,

БОАЖС:

- Агаар орчны бохирдлыг бууруулах хөрөнгө оруулалт /Архангай/ ТАХ-ний эрхийг 2019 оны 6 дугаар сарын 03-нд шилжүүлснээс худалдан авах ажиллагааг 2019 оны 10 дугаар сард зохион байгуулж, 11 дүгээр сард гэрээ байгуулан тоног төхөөрөмжийг хүлээн авсан ч ашиглаж эхлээгүй.

ХХААХҮС

- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Боржигон-эко төсөл/ ТАХ-ний эрхийг Говьсүмбэр аймгийн Засаг даргад 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А/185 дугаар тушаалаар шилжүүлснээс тендер шалгаруулалт оройтож, хугацаа алдан 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдөр гэрээ байгуулсан.

2.43. Орон нутагт эрх шилжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагууд аудит хийж, нийт 127.0 тэрбум төгрөгийн 265 зөрчлийг илрүүлж, 27 зөрчилд 3.4 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 91 зөрчлийг арилгуулахаар 74.3 тэрбум төгрөгийн албан шаардлага өгч, 42.5 тэрбум төгрөгийн 133 зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгч, 6.7 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 14 саналыг дээд шатны удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 15. Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын илрүүлсэн зөрчил /сая төгрөг/

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	Нийт зөрчлийн дүн		Үүнээс,							
				Зөвлөмж өгсөн		Төлбөрийн акт тогтоосон		Албан шаардлага өгсөн		Хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Архангай	10	1,273.9	5	-	-	-	4	1,273.9	1	-
2	Баян-Өлгий	5	3,596.4	4	-	-	-	1	3,596.4	-	-
3	Баянхонгор	13	8,638.6	7	7,556.1	4	132.5	2	950.0	-	-
4	Булган	13	932.0	3	-	5	8.6	4	923.4	1	-
5	Говь-Алтай	17	5,671.2	5	-	1	3.3	7	5,592.9	4	75.0
6	Говьсүмбэр	10	1,521.8	7	585.0	1	0.9	2	935.9	-	-
7	Дархан-Уул	1	618.9	1	618.9	-	-	-	-	-	-
8	Дорноговь	18	5,943.1	14	3,230.7	-	-	4	2,712.4	-	-
9	Дорнод	10	9,662.3	5	2,070.6	-	-	3	7,591.7	2	-
10	Дундговь	13	4,038.9	9	-	1	3.9	3	4,035.0	-	-
11	Завхан	17	4,754.9	4	4,708.7	5	20.5	8	25.7	-	-
12	Орхон	12	851.6	7	-	-	-	5	851.6	-	-
13	Өвөрхангай	13	8,070.3	8	4,338.0	1	80.2	4	3,652.1	-	-
14	Өмнөговь	2	1,386.5	-	-	-	-	2	1,386.5	-	-
15	Сүхбаатар	3	655.5	2	-	-	-	1	655.5	-	-
16	Сэлэнгэ	4	894.4	-	-	-	-	4	894.4	-	-
17	Төв	21	15,088.9	6	-	6	79.9	9	15,009.0	-	-
18	Увс	12	3,037.3	5	-	2	3,024.5	5	12.8	-	-
19	Ховд	4	23,633.6	-	-	-	-	4	23,633.6	-	-
20	Хөвсгөл	17	18,847.0	14	18,310.8	-	-	3	536.2	-	-
21	Хэнтий	20	7,915.3	7	1,105.0	1	0.5	6	71.5	6	6,738.3
22	Нийслэл	30	-	20	-	-	-	10	-	-	-
Дүн		265	127,032.4	133	42,523.8	27	3,354.8	91	74,340.5	14	6,813.3

Эх сурвалж: Орон нутаг дахь Төрийн аудитын газар

¹⁹ Захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх



2.44. Аудитаар аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагууд дараах зөрчлийг илрүүлсэн байна. Тухайлбал,

Төлбөр барагдуулах акт тогтоосон зөрчлийн тухайд:

- БНХАУ-ын "Шинжиа-Шинфа" ХХК нь Улаангом-Наранбулаг чиглэлийн 90 км хатуу хучилттай авто замын барилгын ажил, Наранбулаг-Хяргас нуур чиглэлийн 85 км хатуу хучилттай авто замын барилгын ажил, Улаангом-Хяргас нуур чиглэлийн 15 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг тус тус хийж ашиглалтад хүлээлгэн өгсөн байна. Уг замыг барихад байгалийн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 2,183.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төлөхөөр байжээ. Үүнээс орон нутгийн төсөвт 1,983.8 сая төгрөгийг төлөөгүй;
- "Хос мөнгөн зам" ХХК нь "Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн барих-шилжүүлэх /ВТ/ концессын гэрээний ажлыг хийж ашиглалтад хүлээлгэн өгсөн байна. Уг замыг барихад байгалийн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1,040.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төлөөгүй;
- Баянхонгор аймгийн Богд сумын соёлын төвийн барилгын гүйцэтгэгч "РМБ" ХХК-д техник хяналтын болон нормчлолын сангийн зардлаас 10.6 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Албан шаардлага өгсөн зөрчлийн тухайд:

- Өвөрхангай аймагт 23 аж ахуйн нэгж их засварын болон барилга угсралтын 3,344.1 сая төгрөгийн гэрээт ажлуудыг төсөвт тусгагдсан хэмжээнээс дутуу гүйцэтгэсэн;
- Өвөрхангай аймагт "Нуган трейд" ХХК-ийн нийлүүлсэн 22.0 сая төгрөгийн вакцины хөргөгч, 54.5 сая төгрөгийн хагас автомат биохимийн анализатор, 60.5 сая төгрөгийн гематологийн анализатор нийт 137.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн урвалж бодис ирээгүй, ашиглах зааварчилгаа, сургалт хийгээгүйгээс шалтгаалж, бүрэн ашиглаагүй;
- Сэлэнгэ аймгийн ЗДТГ нь Ерөө сумын Бугант тосгоны 1,845.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний ажлын үнэд тохируулга хийж, гэрээнд Засгийн газрын тогтоолоор баталснаас 343.8 сая төгрөгөөр илүү дүнгээр нэмэлт өөрчлөлт оруулсан;
- Архангай аймагт БОАЖС-аас эрх шилжүүлсэн "Хог боловсруулах үйлдвэр ашиглалтад оруулах" ТАХ-ний хүрээнд нийлүүлсэн тоног, төхөөрөмж, ЦДАШ-ыг ажиллуулж хүлээн аваагүй, ашиглалтыг эхлүүлж үйлдвэрийг ашиглалтад оруулаагүй байна.

2.45. Захиалагчийн болон зохиогчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс орон нутагт хэрэгжсэн барилга угсралтын болон их засварын ажлын чанар ашиглалтын шаардлага хангаагүй, Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, норматив, стандарттай нийцэхгүй байна. Тухайлбал,

ЭМС:

- Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Баянхонгор, Жинст сум/ - Шинэ өлгийн зам ХХК барилга, угсралтын ажил гүйцэтгэж байгаа боловч аймгийн МХГ-аас шалгалт хийж, дараах зөрчлүүдийг илрүүлж, барилга угсралтын ажлыг түр зогсоож, зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн. Үүнд:
 - Барилгын багануудын тэнхлэг хоорондын зай зургаас 1-2 см-ийн алдаатай, шилжилттэй, хэв хашмалын геометр хэмжээ алдсанаас бетон цүлхийсэн,
 - Бетоны найрлагад орсон элс, хайргыг угааж, шигшиж ангилж, холбогдох стандартын дагуу зуураагүйгээс хайрга, элс нь бөөгнөрч бетоны бат бэх байдлын тогтворт байдал алдагдсан,
 - Өргийн хэвтээ, босоо заадас 2-3 см зуурмагт налархайжуулагч хэрэглээгүй,
 - Баганаас өргийн гаргалгаа арматур гараагүй,
 - Барилгын хоёрдугаар давхрын хучилтын бетоны нягтруулалт хангалтгүй, элс хайрга холигдоогүй, бат бэх төслийн шаардлагад нийцэхгүй,
- Эмнэлгийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Нарийнтээл сум, Баянтээг эмнэлэг/ - Жигүүр-Оргил ХХК 294.6 сая төгрөгөөр гүйцэтгэсэн боловч барилгын гадна хана хэсэг газарт хагарч өмөрч унасан, дотор өрөөнүүдийн хана хагарсан, зарим өрөө мөөгөнцөртсөн, чийг ихтэй, коридорын ханыг тосон будгаар будаагүй,
- Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Архангай, Жаргалант сум/ - их засварын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч агааржуулалтын хоолой ажиллахгүй, шал нь хазгай гэх мэт чанарын шаардлага хангахгүй байгаа талаар ашиглагчаас гомдол ирүүлсэн,
- Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Завхан, Сонгино сум/ - аудитын явцад тус барилга дээр очиж үзэхэд дараах ажлууд хийгдээгүй, комиссын үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй, зарим ажлыг дахин хийлгэх шаардлагатай байх тул албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:
 - Байшингийн гадна ханын шавардлагад хөндлөн цууралт үүссэнд маяк тавьж заслыг дахин гүйцэтгэгчээр хийлгэх,
 - Цэвэр ус холболт, шатны бариул, дотор хаалганы шил, серверийн холболт, бохирын худгийн таг, узелийн өрөөний хог шүүгч, холбооны гадна холболт зэргийг гүйцэтгэж хийх,
 - Барилгын газардуулгыг хэмжиж баталгаажуулах,
 - Мөн тус барилгын цэвэр ус ороогүй, уурын зуух барих зурагтай 4 сум нэгдсэн халаалтад холбогдсон учраас оронд нь халуун ус барихаар захиалагч, гүйцэтгэгч гэрээ хийсэн байна.

БСШУСС:

- Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 97 дугаар сургууль/ ТАХ-ний гүйцэтгэгч "Молор констракшн" ХХК усны хаялгыг дутуу хийсэн, дотор хана зарим хэсэгтээ хагарч цуурсан, гадна ханын зарим хэсэгт шавардлагыг нимгэн хийсэн, зарим анги танхимын цонхыг гажилттай суулгасан, зургийн дагуу дээврийг гурвалжин /шувуун/ хэлбэртэй



- хийсэн нь өвлийн улиралд мөс ихээр хуримтлагдан хүүхдийн дээрээс унах аюултай. Ашиглагч байгууллагаас дулаан алдагдал ихтэй байгааг мэдэгдсэн байна. Мөн гүйцэтгэгч нь ашиглагчийн хүсэлтийн дагуу ариун цэврийн өрөөний зохион байгуулалтыг батлагдсан зургаас өөрчилж хийсэн;
- Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 23 дугаар сургууль/ ТАХ-ний гүйцэтгэгч “Грийн ресурс констракшн” ХХК барилгын шатны босгоны өндрийн хэмжээг алдсан, анги танхимын цонх нь буруу тийшээ онгойдог;
 - Сургуулийн барилгын өргөтгөл, 450 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 50 дугаар сургууль/ ТАХ-ний гүйцэтгэгч “Ган мөнхжин” ХХК анги танхимын цонхийг буруу тийшээ онгойхоор хийсэн;
 - Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 10 дугаар хороо/ ТАХ-ний гүйцэтгэгч “Сан-Эрчим” ХХК анги танхимын цонхийг буруу тийшээ онгойхоор хийсэн, ханын шавардлагын зарим хэсэгт хагаралт үүссэн, гал тогооны өрөөний агааржуулалт муу;
 - Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 52 дугаар сургууль/ ТАХ-ний гүйцэтгэгч “Эм Жи Эл Би” ХХК барилгын шатны өндрийн хэмжээг алдсан, анги танхимын цонх нь буруу тийшээ онгойдог, дээрээс ус алдсан;
 - Цэцэрлэгийн барилга худалдан авах /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо, Гандангийн дэнж/ ТАХ-г худалдан авахдаа МХЕГ-ын даргын 2017 оны “Үлгэрчилсэн дүрэм батлах тухай” А/179 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Сургалт-хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.4²⁰, 2.5²¹, 2.9²², 3.6²³-д заасан шаардлагыг зөрчсөн байна.
 - Сургуулийн барилга, 320 суудал /Өвөрхангай, Хархорин сум/ ТАХ-ний гүйцэтгэгч “Химон констракшн” ХХК 3,446.1 сая төгрөгөөр гүйцэтгэсэн бөгөөд араг бүтээцийн цутгалт болон дүүргэлтийн хана хоорондын хагарал маш их, коридор болон ангиудын даацын хана 2 талдаа ижил хагаралтай, спорт заалны урд хэсгийн дээрээс олон хэсэгт дусаал гоожсон, коридорын шалны ихэнх хэсгийн угуурга нь салж, ангайсан, шалны чанар муу, спорт заалны гадна талд усны хаялга хийгээгүй, дээврийн уналтын хэмжээг дутуу хийснээс болоод барилга, заал хоёрын залгаа хэсэгт ихээхэн цас хуралдаж дусаал гоождог, урлаг заалны сэндивч долгионт дээврийн ус унах чиглэлийг буруу чиглэлд байрлуулан гүйцэтгэснээс үүдэн барилгын үндсэн хэсгийн дээвэрт ихээхэн хур тунадас хуралдаж дусаал гоождог;
 - Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум/ ТАХ-ний гүйцэтгэгч “Цагаан бургалтай” ХХК 956.6 сая төгрөгөөр гүйцэтгэсэн бөгөөд гадна фасадын өнгө сэргээх, цахилгааны өрөөний ерөнхий кабельт туннел гаргаж шал цутгах, төмөр сараалжин хашааны шугаман суурь хийх, гадна явган зам нэмэх, давхар хоорондын өрлөгийн зааг засварлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний замыг дахин цутгах, хооллох заалны хэмжээ жижиг, гал тогоонд 380 вольтын тог оруулах байсныг 220 вольтын тог оруулснаас гал тогооны тоног төхөөрөмжүүдийг ашиглах боломжгүй болсон, дотор ханыг лакдаагүй, давхар хоорондын өрлөг завсартай баригдсан;
 - Цэцэрлэгийн барилга, 75 ор /Өвөрхангай, Хархорин сум/ ТАХ-ний гүйцэтгэгч “Хангай-Энержи” ХХК 755.8 сая төгрөгөөр гүйцэтгэсэн боловч араг бүтээцийн бетон цутгалт дүүргэлтийн хана хоорондын залгаа хэсгээр хагарал ихтэй, 1 өрөөний паркетан шал хөөсөн, 2 дугаар давхрын нүүрэн хэсгийн цонхнууд хагарсан;
 - Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг “Девсофт” ХХК 79.5 сая төгрөгөөр гүйцэтгэсэн боловч ажлын тоо хэмжээнд заагдсан ариун цэврийн өрөөний хананд плитаг 127.3 м² наах байснаас 61.3 м² наасан, хаалга угуурга хэсгээрээ хөндийрч завсартай болсноос зарим нь бүрэн хаагдахгүй, зарим өрөөний замаска хуурч унасан, цонхонд мөөгөнцөр үүсэж, амлагааны замаска хуурсан;
 - Соёлын төвийн барилга, 250 суудал /Өвөрхангай, Бат-Өлзий сум/ ТАХ-г гүйцэтгэгч “ДШЛ” ХХК 1,240.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн боловч ажлын чанар хангалтгүй, зарим цонх хагарсан, араг бүтээцийн бүс бетон цутгалт болон дүүргэлтийн хана хооронд цууралт хагарал үүссэн, 2 дугаар давхрын байгууламжийн угаалгын өрөөний суултуур, тосгуур нь ажилладаггүй, үзэгчдийн танхимын таазнаас дусаал гоождог;
 - Соёлын төвийн барилга, 250 суудал /Өвөрхангай, Гучин-Ус сум/ ТАХ-г “Нью констракшн” ХХК 853.9 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэснээс барилгын төсөвт үзэгчдийн танхимын шалыг 242.3 м² талбайд хивсэнцэр дэвсэхээр тусгасныг вааран хавтангаар хийсэн нь үзэгчид халтирч гэмтэх өндөр эрсдэл үүсгэсэн;
 - Соёлын төвийн барилга, 250 суудал /Өвөрхангай, Хархорин сум/ ТАХ-г “Харшийн гэгээ” ХХК 1,262.1 сая төгрөгөөр гүйцэтгэхдээ араг бүтээцийн цутгалт болоод дүүргэлтийн хана хооронд хагарал

²⁰ 2.4. Сургалт-хүмүүжлийн барилга байгууламжийг хөдөлгөөн, дуу шуугиан ихтэй гудамж, төмөр зам, үйлдвэрийн дуу шуугиан, химийн хорт бодис, хорт хий, утаа, тортог, цацраг тоос болон бусад бохирдуулж болох эх үүсвэрээс 500-аас доошгүй метр, үйлдвэр, ахуйн хатуу, шингэн хог хаягдлаас 200 метрээс доошгүй зайд үер, гал, усны аюулд өртөхөөргүй газарт барьж байгуулна. Сургуулийн барилгыг гэрэл сайн тусахаар урагшаа буюу зүүн урагш харуулан барина.

²¹ 2.5. Сургалт хүмүүжлийн байгууллага нь өөрийн эдэлбэр газартай байна. Эдэлбэр газрын эргэн тойронд бут, сөөг тарьж ногоон байгууламж байгуулах ба нийт талбайн 50-иас доошгүй хувийг зүлэгжүүлэн, мод тарьж, 50 хүртэлх хувийг цардаж зассан байна. Модыг барилгын цонхноос 10 м-ийн зайд, бут, сөөгийг 5 м-ээс доошгүй зайтай тарьж суулгана.

а/ Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага: 150 хүртэл суудалтай-Сургалт- хүмүүжлийн байгууллагын эдэлбэр газар Хичээллэх Биеийн тамир спортын, амралтын, аж ахуйн.

²² 2.9. Барилгын давхрын дээд хязгаарыг хүснэгт 3-д заасны дагуу тогтооно.

²³ Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага 2 давхар

3.6. Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын барилга, байгууламжийн агаар солилцооны давтамж, агаарын тооцооны температурыг хүснэгт 6-д заасны дагуу төлөвлөнө.